



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2017 • VII • № 9



**Р.САРАНЦЭЦЭГ: ИРГЭДИЙН
МӨНГӨН ДЭВСГЭРТЭД
ХАНДАХ ХАНДЛАГА
ТОДОРХОЙ ХЭМЖЭЭГЭЭР
ӨӨРЧЛӨГДСӨН**

**МОНГОЛ ХЯТАДЫН ТӨЛБӨР
ТООЦООГ ҮНДЭСНИЙ
МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР
ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ АСУУДАЛ
ХӨНДӨГДЛӨӨ**

**БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН
МӨНГӨН ТЭМДЭГТ**

"Монгол Улсын Эрдэнэсийн сан" ном уншигчдын гарт хүрлээ



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn

“МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САН” ХОЁР ДАХЬ БҮТЭЭЛЭЭ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА



Монголбанк “Эрдэнэсийн сан” дахь шилмэл үзмэрүүдээсээ дээжилсэн “Монгол Улсын Эрдэнэсийн сан” номыг уншигч, сонирхогчдын гарт өргөн барилаа. Өдгөө уг сангийн үзмэрийн тухай хоёр дахь бүтээл болж буй отгон ном нь Монголчуудын түүхийн хөгжлийн урт удаан замыг туулахдаа үлдээсэн өвөрмөц соёл зан заншил, өөрсдийн гэсэн гоо зүй, ертөнцийг үзэх үзлийг шингээсэн эд өлгийн дурсгалуудаас бүрдсэн ба хүрэл зэвсгийн үеэс дундад зуун болон орчин цагийн үеийг хамруулсан байна. Мөн үндэсний мөнгөн тэмдэгт болох цаасан болон зоосон мөнгө, дурсгалын зоос, алтан маркнуудыг ч сонирхуулжээ. Тухайн үзмэр тус бүр нь монгол англи хэл дээр дэлгэрэнгүй тайлбартайгаараа онцлог юм. Уг номыг бүтээхэд Монголын Үндэсний Музейн эрдэмтэн, судлаачид хамтран оролцлоо.



Монголбанкны санаачилгаар нэн ховордсон амьтдын жагсаалтад орсон говийн **Мазаалай** баавгайг дотоод, гадаадын зах зээлд сурталчлан таниулах зорилгоор дурсгалын мөнгөн зоосыг цутгууллаа.

Зоосны үзүүлэлт:

Цутгасан он:	2017
Худалдах үнэ:	300,000 төгрөг
Металл:	Мөнгө. 999 сорьцтой
Жин:	1 унци
Диаметр:	38.61 мм

Онцлох мэдээ:

7-р сарын онцлох үйл явдлууд

ХУУДАС

5

Ярилцлага:

Р.Саранцэцэг: Иргэдийн мөнгөн дэвсгэртэд хандах хандлага тодорхой хэмжээгээр өөрчлөгдсөн

ХУУДАС

7

Байр суурь:

мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ яагаад чухал вэ?

ХУУДАС

9

Нийтлэл:

Монгол Хятадын төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай асуудал хөндөгдлөө

ХУУДАС

10

Инфографик:

Улаанбаатар хотын инфляци

ХУУДАС

12

Орон нутаг:

Дорноговь аймаг дахь Монголбанкны хэлтэс

ХУУДАС

13

Мөнгөн тэмдэгтийн түүх:

Богд хаант Монгол Улсын мөнгөн тэмдэгт

ХУУДАС

15

Дэлхийн эдийн засаг:

Эдийн засагчид ямар хэрэгтэй вэ?

ХУУДАС

23

Банкир:

Д.Төмөрхүү: Харилцагчиддаа төвөгтэй байдлыг үүсгэхгүй байх нь манай гол зорилго

ХУУДАС

27

Санхүүгийн боловсрол:

Хүүхдүүд санхүүгийн боловсролыг ахуйгаасаа (Эцэг эхээс) авч байдаг

ХУУДАС

32

Судалгаа:

Мөнгөн тэмдэгтийн насжилтын тухай

ХУУДАС

34

"Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ" аян:

Төгрөг хүүгийн зовлон

ХУУДАС

37

Монголбанкны үйл ажиллагааны үр дүн эерэг гарав



Монголбанкны 2017 оны 2-р улирлын байдлаарх үйл ажиллагааны үр дүн 125.2 тэрбум төгрөгийн үр дүнтэй гарч, улмаар 2012 оноос хойш тогтмол өсөн нэмэгдэж байсан алдагдлын хэмжээ анх удаа буурлаа. Тайлант хугацаанд санхүүгийн үзүүлэлт эерэг гарахад төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн чангаралт голлон нөлөөлжээ. Монгол Улс ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдахаар болж, төгрөгийн ам.доллартай харьцах ханш чангарч, үүнтэй холбоотойгоор Монголбанкны гадаад болон дотоодын өр төлбөрийн хэмжээ буурсан нь санхүүгийн тайланд эерэг өөрчлөлт бий болох нөхцөлийг бүрдүүллээ.

Алт тушаалтын хэмжээ 5.5 хувиар нэмэгдэв

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 12 сарын 14-ний өдрийн тушаалаар дотоодын аж ахуйн нэгжүүдээс худалдан авах алт /цагаан мөнгө/-ны үнийн бодлогод өөрчлөлт оруулж, дэлхийн зах зээлийн үнээр буюу Лондонгийн Үнэт Металлын Биржийн хамгийн сүүлд зарлагдсан ханшаар худалдах боломжтой болсон юм. Үүнээс хойш алт тушаалт идэвхжиж 2016 оны зургаадугаар сарын 30-ны өдрийн байдлаар иргэд аж ахуйн нэгжүүд Монголбанкинд 6.8 тонн алт тушааж байсан бол 2016 оны жилийн эцэст алт тушаалт түүхэн дээд хэмжээ буюу 18.6 тоннд хүрч байв. Харин энэ оны эхний хагас жилийн байдлаар Монголбанк нийт 7.2 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өсчээ.



“Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ” аян амжилттай өндөрлөлөө



Монголбанкнаас “Мөнгөн тэмдэгтийн соёлтой” хэрэглээ аяныг өнгөрсөн Хоёр сарын хугацаанд улс орон даяар хэрэгжүүлж 7-р сарны 25-ны өдөр хаалтын арга хэмжээг зохион байгууллаа. Энэ үеэр “Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ” аяныг идэвхтэй дэмжиж, хамтран ажилласан банкууд болон сэтгүүлчдэд Монголбанкны зүгээс талархал илэрхийлж, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулав. Орон даяар хэрэгжүүлсэн аяны хүрээнд нийт хүн амын тал хувьд нь бодитоор хүрч ажилласан байна.

Монголбанкны “Баруун бүсийн удирдах ажилтны зөвлөгөөн” болов

Монголбанкны “Баруун бүсийн удирдах ажилтны зөвлөгөөн” Увс аймгийн Улаангом хотод 2017 оны 7 дугаар сарын 22-ноос 25 ны өдрүүдэд боллоо. Зөвлөгөөнийг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан даргалж, Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, мөнгөний бодлого, баруун бүсийн Монголбанкны салбаруудын зохион байгуулалт, хяналт шалгалтын ажил, эрсдэл аюулгүй байдлын асуудал, бүртгэл тооцоо, эмиссийн үйл ажиллагаа зэрэг илтгэлүүдийн хүрээнд шийдвэрлэвэл зохих болон цаашид хийж хэрэгжүүлэх санал санаачилгуудыг дэвшүүлж, харилцан санал солилцлоо.



Эдийн засгийн судалгааны шинэ сэтгүүлтэй болов

Монгол Улсын санхүү, эдийн засгийн нөхцөл байдал, шийдвэрлэх арга замуудын талаарх судалгаа, дэвшүүлсэн санал дүгнэлтүүдийг эмхтгэсэн “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл шинээр хэвлэгдлээ. Тус сэтгүүлийн зөвлөл нь Монгол Улсын нийгэм эдийн засгийн болон дэлхийн улс орнуудын хөгжлийн туршлагын талаар сонирхон судалдаг эрдэмтэн судлаач, шинжээчид, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Сэтгүүлийн анхны дугаарт Монгол Улсын банкны хоёр шатлалт тогтолцооны хөгжлийн туулсан зам, шинэчлэлийн эхлэл, хүртсэн сургамж, даван туулах сорилтын тухай, санхүүгийн тогтвортой байдал, мөнгөний ханш гэх зэрэг 10 гаруй судалгаа нийтлэгдсэн байна.



Банкны ажилтнуудад “СВИФТ” сүлжээний аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулав



Олон улсын “СВИФТ” байгууллагын бүсийн захирал Мэттью де Херинг, СВИФТ-ийн шинжээч Бернанд Спитз, “Аллианс Факторс”-ын техникийн асуудал хариуцсан дарга Светлана Левина болон холбогдох мэргэжилтнүүд манай улсад 2017 оны 7-р сарын 24-ний өдөр ирж, банк, санхүүгийн байгууллагын мэргэжилтнүүдэд зориулан “СВИФТ” сүлжээний оролцогчийн аюулгүй байдлын шинэ програм /Customer Security Program/-ын талаар сургалт зохион байгууллаа. Сургалтаар сүлжээний аюулгүй байдлын шинэ програмын талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, холбогдох сэдвүүдээр илтгэл тавьж хэлэлцүүлээ.

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллагын Ази Номхон далайн бүс нутгийн бүлгийн хурал болов

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллагын Ази Номхон далайн бүс нутгийн бүлгийн жилийн хурал Шри Ланк улсад 7-р сарын 16-наас 21-ний өдрүүдэд боллоо. Тус хурлаар Монгол Улсын ээлжит үнэлгээг хэлэлцэн, үнэлгээний тайлангийн эцсийн хувилбарыг баталлаа. Тайланг батлуулсантай холбоотойгоор цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг гаргаж, ОУВС, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк мөн АНУ-тай хамтран ажиллахаар тохиролцсон байна.





Р.САРАНЦЭЦЭГ: ИРГЭДИЙН МӨНГӨН ДЭВСГЭРТЭД ХАНДАХ ХАНДЛАГА ТОДОРХОЙ ХЭМЖЭЭГЭЭР ӨӨРЧЛӨГДСӨН

Монголбанкнаас “Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ” хоёр сарын аяныг зохион байгуулсантай холбогдуулж Монголбанкны Мөнгөн тэмдэгтийн газрын захирал Р.Саранцэцэгтэй ярилцлаа.

► Таны өдөр тутмын ажил “төгрөг”-тэй холбоотой шүү дээ. Үндэсний мөнгөн тэмдэгтэд иргэд хэрхэн ханддагийг та бусдаас илүү сайн мэдэх хүний хувьд энэ тухай сэдвээр ярилцлагаа эхэлье.

-Монголбанк хуулинд зааснаар өөрийн үндсэн үүргийн нэг болох мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах, хүчинтэй үгүйг тодорхойлох ажлаа өдөр тутам тасралтгүй явуулж, шаардлагатай судалгаа, тооцооллуудыг хийсээр байгаа. Гүйлгээнд эргэлдэж байгаа төгрөгийн маань чанарын байдал ерөнхийдөө маш их муудсан байгааг би өмнөх

МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ Р.САРАНЦЭЦЭГ

1998–2002: Монголбанкны Мөнгөний бодлогын газарт эдийн засагч

2002–2005: Мөнгөний бодлого, судалгааны газар ахлах эдийн засагч

2005–2016: Монголбанк, Мөнгөний бодлого, судалгааны газар, Мөнгөний бодлогын хэлтсийн захирал

2016: Монголбанк, Мөнгөн тэмдэгтийн газар, захирал

БОЛОВСРОЛ, МЭРГЭЖИЛ

1991: ОХУ-ын Санкт-Петербург хотын Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль, эдийн засагч

2004: АНУ-ын Колумбын Их Сургууль, Төрийн удирдлагын магистр (Эдийн засгийн бодлогын менежмент)

ярилцлагандаа дэлгэрэнгүй дурдаж байсан. Хуучирч үнгэгдэн өнгө зүс нь алдагдсан, хиртсэн, урагдсан, нэг багцад байх 3 дэвсгэрт тутмын нэг нь туузан наалттай, эсвэл хамгаалалтын элемент нь арилсан гэх мэтээр гүйлгээнд явуулах шаардлагыг хангахгүй тэмдэгтүүд асар их болсон байгаа. Монголбанкны Мөнгөн тэмдэгтийн газар шаардлагатай арга хэмжээг авч байгаа хэдий ч олон нийтийн бэлэн мөнгөтэй харьцах соёл, сэтгэлгээг давхар өөрчлөхгүйгээр сайн үр дүнд хүрэхгүй юм. Иргэдийн энэ талаарх соёл, сэтгэлгээ маш тааруу байна. Ийм учраас бэлэн мөнгөний харилцаанд байнга оролцож байдаг банкууд, үйлчилгээний компаниуд, иргэдийг шат шатанд нь тус бүрт нь хамарсан сурталчилгаа, мэдээлэл, танилцуулгыг хүргэх зорилготой “Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ аян”-ыг улсын хэмжээнд орон нутаг дахь өөрийн хэлтэс салбарууд болон банкуудаар дамжуулан өнгөрсөн 2 сарын хугацаанд явуулсан юм.

► Монголбанкнаас санаачилсан “Мөнгөний соёлтой хэрэглээ” аян хоёр сарын хугацаатай хэрэгжих үед үр дүн хэрхэн мэдрэгдэж байна вэ, цаашид энэ ажил тогтмол үргэлжлэх байх гэж бодож байна?

-Ер нь аянаас бидний хүлээж буй үр дүнг дүрсэлбэл гүйлгээнд эргэлдэж буй цаасан мөнгөний байдал ерөнхийдөө нийтээрээ цэвэрхэн, элэгдэж урагдаагүй, туузан наалтгүй байх бөгөөд үйлчилгээний газруудад төлбөр тооцоо хийж буй аливаа иргэдийг харвал үргэлж хэтэвчнээс цэвэрхэн дэвсгэрт гарган үйлчлүүлж байгааг харах явдал юм. Гэхдээ одоо аяны үр дүнг хэлэхэд эрт байна. Яагаад гэвэл энэ асуудал маань өөрөө цаг хугацаа нэлээд шаардсан, өөрийн гэсэн онцлогтой. Тухайлбал, манай аян амжилттай хэрэгжиж, үр дүнд нь иргэдийн бэлэн мөнгөтэй харьцах хандлага өөрчлөгдөж, соёлтой хэрэглээнд дадаж эхэлсэн ч гэлээ нэгэнт хэдийнээ хуучирч элэгдсэн дэвсгэртүүд нэг хэсэг гүйлгээнд эргэлдэж л байх болно. Учир нь гүйлгээнд гаргасан нийт бэлэн мөнгөний зөвхөн 30-аад хувь нь л арилжааны банкны кассаар дамждаг бөгөөд зөвхөн энэ хэсэг нь л тодорхой хугацаанд Монголбанкинд ирж ялгагдаж цэгцлэгдэнэ гэсэн үг. Үлдсэн хэсэг нь иргэд, компаниудаар дамжин эргэлдэж байгаад хэзээ банкинд тушаагдана тэр цагт л цэвэрлэгдэх боломжтой юм. Иймээс цаг хугацаа хэрэгтэй. Мөн бидний зүгээс соён гэгээрүүлэх ажлаа байнга хийсээр л байх болно. Ингэж байж иргэдийн сэтгэлгээ өөрчлөгдөнө гэж бодож байна.

► **Аяны хүрээнд та бүхэн чухам ямар үр дүнд зорьж ажлаа чиглүүлсэн бэ, арилжааны банкууд ч мөн үүнд идэвхтэй оролцсон шүү дээ?**

-“Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ аян”-д зарим арилжааны банкууд тухайлбал, Худалдаа хөгжлийн банк, Ариг, Капитал, Богд зэрэг банкууд маш идэвхтэй дэмжиж оролцсон, тодорхой хэмжээгээр хөрөнгө зарцуулсан байгаа. Түүнчлэн энэ аян маань хөдөө орон нутагт ч өргөн хүрээтэй явагдсан бөгөөд үүнд орон нутаг дахь Монголбанкны салбар хэлтсүүд ихээхэн чармайлт гаргаж ажилласан. Аяны хүрээнд иргэдийн сэтгэлгээг өөрчилж соён гэгээрүүлэх чиглэлд бид хамтраад маш олон төрлийн ажлууд хийсэн. Жишээ нь сурталчилгааны чиглэлээр зурагт хуудас, самбар, хөдөлгөөнт инфографик зэргийг бүтээж, олон нийтэд тарааж цацсан, цаашдаа тогтмол сурталчилгаандаа ашиглаж байх сайн бүтээлтэй болох зорилгоор сэтгүүлч нар болон олон нийтийн дунд эссе, нийтлэл, шүлэг, зургийн уралдаан зарлаж шалгаруулсан, өргөн хүрээтэй сургалтыг дор бүрнээ зохион байгуулсан, хүнсний зах үйлчилгээний газруудад банкны ажилтнууд очиж олныг

“Аян амжилттай хэрэгжиж, үр дүнд нь иргэдийн бэлэн мөнгөтэй харьцах хандлага өөрчлөгдөж, соёлтой хэрэглээнд дадаж эхэлсэн ч гэлээ нэгэнт хэдийнээ хуучирч элэгдсэн дэвсгэртүүд нэг хэсэг гүйлгээнд эргэлдэж л байх болно.”

хамарсан өдөрлөг, арга хэмжээнүүдийг явуулсан, АХА, Центавар тэмцээн, ТВ-ийн нэвтрүүлэг, сурвалжлагууд, орон нутагт уул, нуруу, овоонд мөнгө тавихгүй байхыг анхааруулах зэрэг олон төрлийн ажлууд хийгдсэн байгаа. Ямар ч байсан хүмүүст тодорхой хэмжээгээр хүрсэн, "наалдсан", нөлөөлсөн байх гэдэгт ихээхэн найдаж байгаа. Цаашдын ажилдаа хэрэг болохуйц гайгүй сайн бүтээлүүдтэй ч болсон.

► **Ярилцлагын төгсгөлд та бид хоёрын ярьсан сэдвийн хүрээнд ямар дүгнэлт хийхийг хүсч байна вэ?**

-Энэ аяны маань сэдэв бол зөвхөн Монголбанкинд, банкуудад хамаатай асуудал биш бөгөөд цаана нь тусгаар улсын маань нэрийн хуудас болсон Монгол төгрөг бол Монголын баялаг, олон улсад Төгрөг нэрээр Монгол улс, түүний түүх, соёл, зан заншил төсөөлөгдөж байдаг тул бүх ард түмэнд хамаатай асуудал гэдгийг ойлгож, бидний санаачилгыг иргэд, олон нийт бүгд дэмжээрэй гэж уриалаад манай аяны хүрээнд явуулсан шүлгийн уралдаанд ирүүлсэн дараах шүлгээр ярилцлагаа өндөрлөө.

Дорноговь аймгийн салбараас зохиож, Хүслийн хайрханы бэлд самбарт байршуулсан шүлгийн төртөөс:

Сүлдэт Монголын мөнгөн тэмдэгт
Сүжгээр өргөх цацал бишийг санацгаа
Соёмбот Монголын бахархалт баялгаа
Салхинд биш хэтэвчиндээ хадгалцгаая
Үндэсний баялаг Монгол төгрөгөө
Уул овоонд биш банкинд хадгалцгаая.

Ярилцсанд баярлалаа.

Монголбанкнаас санаачлан нийт банкуудтай хамтран “Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ” аяныг орон даяар 5-р сарын 1-нээс 7-р сарын 30-ны өдрийг хүртэл хэрэгжүүлж, үндэсний мөнгөн тэмдэгт “төгрөг”-т нийтлэг ажиглагдаж буй хэрэглээний буруу хэвшлийн эсрэг нийгмийг соён гэгээрүүлэх ажлуудыг хийсэн билээ. Энэ талаар олон нийтийн байр суурийг хүргэж байна.

МӨНГӨН ТЭМДЭГТИЙН СОЁЛТОЙ ХЭРЭГЛЭЭ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?



Гандантэгчинлэн хийдийн Тэргүүн хамба лам **Д.Чойжамц:**

Сүсэгтэн олны өргөж байгаа мөнгөн өргөл хандив эзэнтэй байх нь зүйд нийцнэ. Эзэнтэй байна гэдэг чинь ямар нэгэн буяны үйлд зориулагдаж байгаа хэлбэр. Тийм болохоор мөнгийг ашиглахгүйгээр аливаа зүйлд хийж, булж орхино гэдэг тусгүй хэрэг. Тэгэхээр төгрөг, мөнгийг аль болох уул овоонд өргөхгүй байх нь зохистой. Бусад оронд бол тиймэрхүү шүтлэгтэй холбоотой мөнгө цугларвал тэр дор нь буцааж аваад л зарцуулах ёстой зөв зүйлд зориулдаг. Мөнгө зохих зүйлдээ зориулагдаж байна гэсэн үг шүү дээ. Үүний учир утгыг “Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ аян”-аар дамжуулж сүсэгтэн олонд ойлгуулах үйлсийг бид ч мөн дэмжин оролцож байна.



Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал **Д.Хүрэлбаатар:**

Мөнгөн тэмдэгт гүйлгээний хэрэгсэл тул гүйлгээндээ тогтвортой удаан хэрэглэгдэх ёстой. Гэтэл мөнгөний бохирдол эдэлгээ нь хүний зохисгүй үйлдлээс болж хурдацтай муудах боллоо. Муудсан ширхэг мөнгө бүрийн төлөө маш их зардал гардаг гэдгийг иргэд ойлгох хэрэгтэй. Ер нь эндээс үзэхэд технологийн дэвшил дээр суурилсан бэлэн бус төлбөр тооцоо, ялангуяа, цахим мөнгө, карт, интернэт банк, гар утсанд суурилсан ухаалаг төлбөр тооцоог өргөн хэрэглэх талаар иргэдэд хүргэх явдал чухлаар тавигдаж байна.



“АйЁо доктор” нэвтрүүлгийн зохиогч, их эмч **Б.Дугархүү:**

Мөнгөн дээр бидний их эзэн Чингис хааны хөрөг байршдгийг хүн бүхэн санаж, дээдэлж, хүндэтгэж явах хэрэгтэй. Түүнээс биш зүгээр нэг базчихсан, халаасандаа хийгээд явж байж болохгүй. Мөнгө бол үнэт цаас. Төлбөрийн баталгаат хэрэгсэл. Монгол Улсын нэрийн хуудас шүү дээ. Үүнийг монголчууд ойлгохгүй, замбараагүй авч яваад сурчихсан байна. Мөнгөн дэх нянгийн бохирдлыг судлахад бүх төрлийн нян илэрч байна. Энэ юутай холбоотой вэ гэхээр иргэдийн мөнгөтэй харьцах сэтгэлгээ дорой байгаатай холбоотой. Гэтэл мөнгөөр бүх төрлийн халдварт өвчний нян бактер дамждаг болохыг иргэд ойлгох хэрэгтэй байна.



Чингэлтэй дүүргийн 2-р багийн иргэн **Н.Аззаяа:**

Мөнгийг нугалаад халааслах, атгаж явах, халтартаж урагдсан мөнгө хэрэглэх зэрэг нь миний хувьд энгийн л үзэгдэл байсан тул тэгж их анхаарч анзаардаггүй байсан. Харин Монголбанкнаас хэрэгжүүлсэн мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ аяны хүрээнд олон нийтэд өгч буй мэдээллүүдийг хүлээн авснаар мөнгөө нугалж түрийвчлэх эсвэл шууд цүнхнийхээ халаасанд нугалаад хийчихдэг байснаа больж байгаа. Хүүхдүүддээ түрийвч авч өгсөн. Их баярлаж байна лээ. Харин мах ногооны худалдагч нарыг бээлий өмсдөг болоосой гэж хүсч байна. Мөнгө барьсан гараараа хүнсний бүтээгдэхүүнтэй харьцаж байна гэдэг эрүүл ахуйн хувьд яагаад ч нийцэхгүй шүү дээ. Тийм учраас бээлий өмсдөг болох хэрэгтэй.



МОНГОЛ ХЯТАДЫН ТӨЛБӨР ТООЦООГ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ АСУУДАЛ ХӨНДӨГДЛӨӨ

Монгол Хятадын банкны салбарын хамтын ажиллагаа жил ирэх тусам өргөжиж, шийдвэрлэвэл зохих асуудлуудын хүрээнд харилцан уулзалтуудыг тогтмолжуулж иржээ. Анхны дугуй ширээний уулзалт 2004 онд болж, үүний үр дүнд Монголбанк ба Хятадын Ардын Банк хоорондын төлбөр тооцооны гэрээ байгуулагдсан байна. Уг гэрээнд төлбөр тооцоонд хоёр улсын арилжааны банкууд бүгд чөлөөтэй оролцох, төлбөр тооцооны бусад хэлбэр тухайлбал аккредитив, зээлийн эрх нээх, Монгол-Хятадын бүх хилийн боомт хотуудад юань, төгрөгийн тооцоог банкаар дамжуулж хийх, хилийн боомтуудад харилцан валют солих цэг нээн ажиллуулах боломж нээж өгснөөрөө уг гэрээ нь Монгол-Хятадын гадаад худалдааг хөгжүүлэх, хоёр улсын банкуудын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бэхжүүлэхэд асар ач холбогдолтой баримт бичиг болсон байна.

Түүнээс хойших хамтын ажиллагааны 7 дахь удаагийн дугуй ширээний уулзалт Улаанбаатар хотноо 2017 оны 7 дугаар сарын 27-ноос 28-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Уулзалтад Монголбанк, Монголын банкны холбоо болон нийт банкууд, Гадаад харилцааны яамны хоёр орны хамтын харилцааны асуудал хариуцсан

албаныхан, Хятадын банкуудыг төлөөлж Хятадын Ардын Банк, Хятадын Банк, Хөрөнгө Оруулалтын Хөгжлийн Банк, Хөдөө Аж Ахуйн Банк, Шанхайн Эдийн Засгийн Хөгжлийн Банк, Аж Үйлдвэрийн Банк, Бао Шань банк, Өвөр Монголын Банк оролцсон юм. Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Хятадын Ардын банкны Олон Улсын Харилцааны газрын орлогч захирал Гүо Кай нарын даргалсан энэ удаагийн дугуй ширээний уулзалтаар оролцогчид ОУ-ын төлбөр тооцоо, бэлэн мөнгөний асуудал, худалдааны санхүүжилт гээд маш өргөн хүрээнд асуудлууд дэвшүүллээ. Мөн хоёр улсын мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцлийн үр дүн, “Нэг зам, нэг бүс” санаачлага зэрэг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн илтгэлүүд тавигдаж хэлэлцүүлсэн юм.

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:
Төлбөр тооцоог түргэн гүйцэтгэхэд үндэсний мөнгөн тэмдэгт ашиглах хэрэгтэй

“Энэ удаагийн уулзалтаар хоёр улсын хооронд Төв банк мөнгөний бодлогоо танилцууллаа. Мөн мөнгөн тэмдэгтээ хэрхэн солилцох тухай санал солилцлоо. Ер нь хоёр орны хувьд худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа идэвхжиж буйтай зэрэгцэн төлбөр тооцоог

түргэн гүйцэтгэхдээ өөрийн улсын мөнгөн тэмдэгтийг түлхүү ашиглах тухай ярилцаж байна. Түүнчлэн банк хоорондын төлбөр тооцоог хийхийн тулд гуравдагч орны мөнгөн тэмдэгтийг ашиглахгүй байх боломжийн талаар хэлэлцлээ. Гадны банкны салбар оруулж ирэх асуудлын тухайд хууль эрх зүйн орчны шинэчлэлийг хийх зайлшгүй шаардлагатай учраас Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийг УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлж байгаа.

Монголын Банкны Холбооны Ерөнхийлөгч О.Орхон: Хятадын хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох тухай ярилцаж байна

-Хоёр улсын гадаад харилцаа, худалдаа томоохон байр суурийг эзэлдэг. Урд хөрштэйгээ сүүлийн 20 гаруй жил банк хоорондын хамтын ажиллагаатай байсан. Тухайлбал, картын болон гадаад худалдааны санхүүжилт, хамтарсан зээл гэх мэтчилэн хамтарч ажилладаг. БНХАУ-ын Төв банкны зүгээс манай улсад зээл олгохдоо тавьж байгаа шаардлага, юань болон төгрөгөөр олгох зээлийг судалж байна. Мөн Хятадын хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох талаар ярилцлаа. Ер нь зөвхөн хил дамнасан худалдаанаас илүүтэй төгрөг, юанийн хэрэглээг хоёр улсад нэвтрүүлэх нь зүйтэй. Ингэснээр гуравдагч орны валютыг бага хэмжээгээр ашиглах бодлого явуулж байх шиг байна. Сүүлийн үед хятадын банкууд төгрөгийн данс нээж эхэлсэн. Тиймээс гадаад валютын нэг эх үүсвэр болно гэж харж байна. Манай банкны тухайд Хятадын “Хөдөө Аж Ахуйн Банк”-тай үйл ажиллагаагаа өргөжүүлэн зээл олгох, гадаад төлбөр тооцоо хийх зэрэг асуудлыг тусгасан санамж бичиг зурлаа.

Хятадын “Ардын Банк”-ны Олон улсын харилцааны газрын захирал Ай Минг: Хөгжихийн тулд хамтдаа зүтгэвэл үр дүнтэй

-Энэ удаагийн уулзалтад оролцож байгаадаа баяртай байна. Өмнөх уулзалтууд үр дүнтэй болж байсан. Ер нь ололт амжилт болон цаашид тулгарч буй асуудлуудаа, цаашид ашиглаж болох боломжийн талаар нүүр тулж ярилцах нь илүү үр дүнтэй байдаг. Хоёр талын хамтын ажиллагаа маш идэвхтэй, амжилттай байгаа. Тухайлбал, своп хэлцлийг дахин гурван жилээр сунгаснаас харж болно. Мөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэх төлбөр тооцоог өргөжүүлэх, санхүүгийн сүлжээг нэмэгдүүлэх, банк хоорондын арилжаа, гүйлгээ,

солилцооны асуудлаар санал солилцож байна. БНХАУ-ын санаачлагаар хэрэгжиж байгаа “Нэг бүс ба нэг зам” хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн салбарын хамтын ажиллагаа улам бүр идэвхжинэ гэж харж байгаа. Өөрөөр хэлбэл, энэ хөтөлбөрөөр дамжуулан хамтдаа хөгжихийг зорьж байна. Хөтөлбөрт хамрагдаж байгаа улс орны хувьд нийтлэг шаардлага байдаг. Үүнд санхүүжилтийн хомсдол ажиглагддаг. Тэгэхээр хөгжихийн тулд хамтдаа зүтгэх хэрэгтэй юм.

Монгол, Хятадын арилжааны банк хоорондын хэлцлийн хэмжээ өсөх хандлагатай байгаа юм. Төлбөрийн тэнцлийн томоохон дарамтыг даван туулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад юанийн своп хэлцэл өөрийн үүргийг гүйцэтгэж байгааг илтгэгчид онцолж байв. Ер нь хоёр улсын банк хоорондын хамтын ажиллагаа санхүүгийн болоод худалдааны салбарт чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, хоёр талын худалдааны хэмжээ жил ирэх бүр өсч байгаа энэ үед мөнгөн тэмдэгтийг харилцан солилцох нь төлбөр түргэн гүйцэтгэхэд дөхөм болох аж.


Хятадын “Ардын банк” гадаадын 36 орны Төв банкттай 3.6 их наяд юань бүхий своп хэлцэл хийжээ. Манай улстай анх 2011 онд таван тэрбум юанийн своп хэлцлийг хийсэн байна. Ингээд 2012 онд дээрх хэлцлийг хоёр дахин нэмэгдүүлэн 10 тэрбум болгож байв. 2013 онд хэлцлийг сунгаж байсан бөгөөд нийтдээ 15 тэрбум юань болгон өсгөсөн юм. Манай улсын эдийн засгийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хамгийн сүүлд 2020 он хүртэл сунгасан гэдгээ Ардын Банкны Мөнгөний бодлогын газрын ахлах мэргэжилтэн Вэн Жанвэй уулзалтын үеэр хэлж байсан юм. Түүнчлэн харилцан хамтын ажиллагаанд Төв банкуудаас гадна арилжааны банкны үүрэг чухал гэдгийг тэрээр онцолж байв. Тухайлбал, арилжааны банкуудын юанийн төлбөр тооцооны үнийн дүн жил ирэх бүр өсч байна. Эндээс харвал, хоёр улсын худалдаа, бизнесийн харилцаа өргөжиж буй энэ үед дотоодын мөнгөн тэмдэгтээр төлбөр тооцоо хийх хандлага нэмэгдэх төлөвтэй байгаа юм. Энэ нь зөв зүйтэй байхаас гадна гадаад шокоос урьдчилан сэргийлэхэд илүү өгөөжтэй. Өөрөөр хэлбэл, макро төвшинд илүү эерэг үзүүлэлтийг авчрах боломжтой. Тиймээс хоёр улсын төрийн зүгээс бодлогын төвшинд дэмжихийг гадны төлөөлөгчид хүсч байлаа.

Улаанбаатар хотын инфляци 6 дугаар сарын байдлаар

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн жилийн инфляци 2017 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 3.3%-д, Улаанбаатар хотын хэмжээнд 3.4%-д хүрлээ.



Инфляци, түүний бүрэлдэхүүн





ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ МОНГОЛБАНКНЫ ХЭЛТЭС

1931 оны 5 дугаар сарын 26-нд аймгийн Анхдугаар Их Хурлыг 23 сумаас сонгогдсон 40 төлөөлөгчтэйгөөр "Сайн ус" гэдэг газар нээн хуралдуулж, аймаг төвлөрөх газрыг хэлэлцээд Далай Сайншандад тогтохоор шийдвэрлэсэн байна. Үүний дараа 1931 оны 6-р сарын 15-ны өдөр Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн банкны Дорноговь аймаг дахь хэлтэс нэртэйгээр дарга, нягтлан, нярав, манаач гэсэн 4 орон тоотой, нэг гэртэй байгуулагдаж ажилласан түүхтэй. 1933-1940 онд банкны үйлчилгээний хүрээ өсч 7 орон тоотой болж хоршоодын холбоо, үйлдвэрийн төлөөлөгчид, улсын худалдаа зэрэг байгууллагуудад богино хугацаатай зээл олгох, ард иргэдийн гар дээр байгаа сул чөлөөтэй бэлэн мөнгийг хадгаламжинд хуримтлуулах, үйлдвэр, аж ахуйн газар, байгууллагын хоорондын тооцоог төлбөрийн даалгавар, инкасс, эрх нээгдүүлсэн чек зэрэг бэлэн бус тооцооны дэвшилтэт хэлбэрийг ашиглан хийж байв.

Банкны хэлтэс нь 1954-1970 он хүртэл аж ахуйн байгууллагуудад урт богино хугацаатай зээл олгож, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх замаар үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгууллага хоорондын төлбөр тооцоог шуурхай болгох, бэлэн мөнгөний эргэлтийг түргэсгэх зэрэг банкны бүхий л үүргийг гүйцэтгэх болсноор улс ардын аж ахуйн зээл, тооцоо, хөрөнгө оруулалтын санхүүжилт, мөнгөн кассын төв болсон юм. БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1978 оны 288 дугаар тогтоолоор банкны аймаг, хот дахь хэлтсүүдийг 1979 оны 1-р сарын 1-ний өдөр контор болгон өргөтгөж, зээл мөнгөн эргэлтийн, бүртгэл гүйлгээний, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гэсэн 3 хэлтэстэй ажиллаж байв.

1938 онд Эрдэнэ, 1942 онд Хөвсгөл суманд банкны анхны тооцооны касс байгуулагдсанаар банкны үйлчилгээ хөдөөгийн сум, багт хүрч эхэлсэн ба 1991 он гэхэд 16 хэлтэс, тооцооны төвийн нийт 120 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байжээ.

Дорноговь аймгийн банкны хэлтэс нь төлөвлөгөөт зорилтоо биелүүлсэн амжилтаар 1976 онд банкны системд 3-р байр, 1977 онд 2-р байр, 1990 онд 1-р байр эзэлж, О.Одцэрэн даргатай Чойрын салбар хэлтэс,

Г.Сарантуяа эрхлэгчтэй Хажуу-Улааны тооцооны кассын хамт олон Улсын банкны системд 2-3 удаа шагналт байр эзэлж байсан ба ажил үйлсээрээ манлайлсан Ч.Осоржам, Г.Батбаяр нар "Алтан гадас" одонгоор, Д.Ханд, Б.Сүхээ, Ө.Сүхочир, А.Адъяасүрэн, Д.Даваасамбуу, Г.Сарантуяа, Н.Должинсүрэн, Ө.Ухнаабаатар нар "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар шагнагдаж байв. Түүнчлэн нярав Ө.Ухнаабаатар нь "Улсын банкны хөдөлмөрийн аварга"-аар шалгарч байжээ.

Монгол Улсын бага хурлаар 1991 оны 4-р сард банкны хууль батлагдаж, банкны төвлөрсөн тогтолцоог зах зээлийн харилцааны шаардлагын дагуу банкны 2 шатлалтай тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн үндэслэл бүрдсэн юм. Монголбанкны Ерөнхийлөгчийн 1991 оны 7-р сарын 04-ний өдрийн 316 тоот тушаалаар аймаг дахь банкны конторыг татан буулгаж Монголбанкны салбар байгуулсан билээ.

Дорноговь аймгийн банкны хэлтэс, конторын дарга нар:

н.Тогтохбуян	1931-1935, 1939-1942 он
н.Мөрзэвэг	1935-1938 он
н.Санжмятав	1942-1943 он
н.Чимэд	1943-1947 он
н.Содномцог	1947-1952 он
З.Зундуйжамц	1952-1956 он
Ж.Пэрэнлэй	1956-1959 он
Ө.Пүрэв	1959-1961 он
Л.Аюуш	1961-1963 он
Г.Шагдар	1963-1965 он
Ц.Дашцэрэн	1965-1968 он
Г.Шагдар	1968-1975 он
Г.Банди	1975-1982 он
Г.Батбаяр	1982-1991 он

Банкны контороос анх "ХОТШ" банк, "Хөдөө Аж ахуйн банк", "Даатгал" банк үүсч байгуулагдахад сумдын болон төвийн тооцооны касс, салбаруудыг харилцагч, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн зээл, хадгаламж, төлбөр тооцооны үйлчилгээг хамтад нь шилжүүлсэн юм.



Дорноговь аймагт арилжааны банкууд байгуулагдсан нь:

- 1991 оны 4-р сарын 01-ний өдөр ХОТШ банкны 408-р салбар,
- 1991 оны 05-р сарын 09-ний өдөр ХААН банкны 604-р салбар,
- 1991 оны 05 сард ДААТГАЛ банкны 218-р салбар,
- 1993 оны 06-р сарын 20-ны өдөр Ардын банкны 529-р салбар,
- 1997 оны 01-р сарын 15-ны өдөр СЭРГЭЭН БОСГОЛТ-ын банкны салбар,
- 1999 оны 03-р сарын 08-ны өдөр МОНГОЛШУУДАН банкны 118-р салбар,
- 2000 оны 04-р сарын 03-ны өдөр ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН банкны 808-р салбар,
- 2001 оны 12-р сарын 19-ний өдөр АНОД банкны 09-р тооцооны төв,
- 2002 оны 01-р сарын 09-ний өдөр ХАС банкны 02-р тооцооны төв
- 2004 оны 07-р сарын 22-ны өдөр Капитал банкны 906-р тооцооны төв
- 2006 оны 04-р сарын 05-ны өдөр Голомт банкны 13-р тооцооны төв

2012 оны 07-р сарын 30-ны өдөр "Капитрон" банкны тооцооны касс нээн ажиллуулах зөвшөөрлийг аван байгуулагдаж байсан ба өнөөдрийн байдлаар ХААН банк, Худалдаа Хөгжлийн банк, Төрийн банк, Хас банк, Голомт банк, Капитал банк, Капитрон банкны гэсэн арилжааны 7 банкны 72 салбар нэгжид хяналт тавин ажиллаж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/98 дугаар тушаалаар Дорноговь аймаг дахь Монголбанкны салбарт бүтцийн өөрчлөлт хийгдэж Монголбанкны хэлтэс болж захирал, нягтлан бодогч, ахлах хянан шалгагч 1, хянан шалгагч 2, нярав, тоологч, жолооч гэсэн 8 орон тоотойгоор Төрийн мөнгөний бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, банкны үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч Монголбанкны салбар хоорондын төлбөр тооцоог хийх, орон нутагт бэлэн мөнгөний эмиссийн ба зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Монголбанкны салбар, хэлтсийн захирлууд:

Гомбожавын Батбаяр	1991-2006
Дондовын Эрдэнэчимэг	2006-2016

Сүхбаатарын Алтанбаатар 2016 оноос өнөөг хүртэл

Тус хэлтэс нь хариуцан ажиллаж байгаа банкны нэгж өндөртэй байдгаас шалтгаалан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн А/48 дугаар тушаалаар Говьсүмбэр аймгийн 3 банкны 12 салбар, тооцооны төвийг Дундговь аймгийн Монголбанкинд шилжүүлсэн байна.

Дорноговь аймгийн нутагт Монгол орны үүд хаалга болсон Замын-Үүдийн хилийн боомт байдгаас шалтгаалан Дорноговь аймаг дахь Монголбанкны хэлтэс нь Төв банкинд жилд 1-3 удаа бэлэн мөнгөний зузаатгал хүргүүлж, Төв банкнаас зузаатгал авдаггүй тул бусад салбар хэлтсээс онцлог юм.



Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнгийн цуглуулгаас "Бага болзоот"

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН МӨНГӨН ТЭМДЭГТ

Богд хаант Монгол Улсын Засгийн газраас 1921 оны 4-р сарын 20-ноос 10-р сарын 20 хүртэл зургаан сарын хугацаатай цаасан мөнгөн дэвсгэртийг 6 хувийн хүүтэйгээр гаргахаар шийдвэрлэсэн байна. Энэ мөнгөн тэмдэгтийг малаар баталгаажуулж гаргасан ба "бага болзоот" гэж нэрлэж байжээ. Бага болзоот мөнгөн тэмдэгтийг модон бараар барлажээ.

Энэ мөнгөн тэмдэгт нь 20, 25, 50, 100-тын долларын дэвсгэртүүдээр гарсан бөгөөд 10-тын доллар нь хонины, 25-тын доллар нь үхрийн 50-тын доллар нь морины, 100-тын доллар нь тэмээний зурагтай байв. Дэвсгэртүүдийн нүүрэн талд "Монгол Улсын сангаас олноо өргөгдсөний арваннэгдүгээр оны арван сарын хорин хүртэл хэмээх хугацаагаар гаргасан бөгөөд нэг зуун хувиас зургаан хувийн хүү үржүүлж бүхүй бага болзоот баталгааны тэмдэг.

Энэхүү баталгааны тэмдэгтийг тушаасан хүмүүн дор уг тогтсон болзооноо Сангийн яамнаас арван /хорин тав, тавь, зуу/ янчааны бэлхэн мөнгөний зүйлийг гүйцэтгэн төлмүй. Үүний тулд гарын үсэг талбарисан: Сангийн яамны тэргүүн сайд /гарын үсэг, дардас/, яамны зөвлөх түшмэл Лавров. Нийслэл хүрээнээ олноо

өргөгдсөний арваннэгдүгээр он, дөрвөн сарын хорин" гэж монгол бичгээр бичсэн байна. Дэвсгэртүүдийн ар талд хонь, үхэр, морь, тэмээний зурагтай, дээд талд нь "Сангийн яамны баталгааны тамга" гэсэн үг бүхий соёмбот тамга даржээ. Эдгээр дэвсгэртүүд дээр монгол, орос, англи хэл дээр бичсэн бичигтэй бөгөөд бүгд 250000 мексик долларын хэмжээтэй гарсан байна.

Энэхүү мөнгөн тэмдэгт нь Барон Унгарн нийслэл хүрээг эзэлж, засгийн эрхийг үнэн хэрэгтээ барьж байх үед гарсан тул монголчууд "Бароны мөнгө" гэж нэрлэх явдал ч байжээ. Энэ мөнгөн тэмдэгт эхлээд мексик доллартай ижил ханштай байж чадсан бөгөөд 1921 оны наймдугаар сараас ханш нь 60 хувь буурч ирсэн. Үүнээс болж ямар нэг муу юм болоогүй бөгөөд харин түүнээс хойш ханш нь унаагүй байна. Ардын Засгийн газраас уг мөнгөн тэмдэгтийг хүчин төгөлдөр хэвээр үргэлжлүүлсэн бөгөөд 1922 оны хоёрдугаар хагаст зөвхөн газрын төлбөрийн хэрэгслийн үүрэгтэй болсон ба дараа нь нийт мөнгө Сангийн яамны кассат эргэж ирсэн гэх мэдээ бий.

Эх сурвалж: "Монгол Улсын зоос, мөнгөн тэмдэгт"
Ч.Энхбат, Б.Нямаа, Ц.Батсайхан



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН ХУРЛААС... 2017.07.25

Монголбанкнаас сар бүр зарладаг хэвлэлийн бага хурлын асуулт, хариултаас хүргэж байна.

-Монголбанкны алт худалдан авах өнөөдрийн ханш хэд байгаа вэ?

Судалгаа, статистикийн газрын ахлах эдийн засагч А.Ананд:

-Манай алтны ханшийг өдөр бүр www.mongolbank.mn вэб хуудаснаас авч болно. Хамгийн сүүлийн мэдээгээр Монголбанк нэг грамм алтыг 97520 төгрөгөөр үнэлж авч байна.

-Алт тушаалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Алт" аяныг эхлүүлэх гэж байгаа юм байна. Энэ аянаас ямар үр дүн хүлээж байгаа вэ?

Монголбанкны хэвлэлийн төлөөлөгч Д.Оргил:

-Алтыг Лондоны металлын биржийн үнэ ханшаар авдаг байх журам батлагдаад, хэрэгжиж байгаа. "Алт" хөтөлбөрийн хүрээнд бид алт тушаалтыг нэмэгдүүлэх, идэвхжүүлэхийг зорьж байна. "Алт" аяныг хэрэгжүүлж, Монголын алтыг зөвхөн Монголбанкиндаа тушааснаар иргэд, аж ахуйн нэгжүүд Монгол Улсын гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, улмаар үндэсний мөнгөн тэмдэгт, төгрөгийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулах боломжтой. Иймд Монголбанкнаас аж ахуйн нэгжүүд, иргэдэд хандан олборлосон алтаа Монголбанкиндаа тушаахыг уриалж байгаа юм. Монголбанкны хувьд алтыг дэлхийн зах зээлийн үнээр авч байгаа гэдгийг дахин онцолъё. Мөн тушаасан алтны төлбөрийг өдөрт

нь шилжүүлдэг гэх зэрэг давуу талтай учраас иргэд, аж ахуйн нэгжүүд олборлосон алтаа Монголбанкинд тушаах нь ямар нэгэн эрсдэлгүй юм.

-Ипотекийн зээл олголт дээр чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэд байгаа вэ. Өмнөх сартай харьцуулахад хэр өөрчлөлттэй байгаа вэ?

-ССГ-ын ахлах эдийн засагч А.Ананд

-Ипотекийн зээл дээр чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн үзүүлэлт аль аль нь 1.8 хувьтай байна. Өнгөрсөн сард энэ үзүүлэлт 1.6 орчим хувьтай байсан. Шинээр олгосон зээлийн хувьд өмнөх сартай харьцуулахад нэмэгдсэн байгаа.

-Валютын хадгаламжийн дүн буурч байгаа шалтгааныг хэрхэн харж байгаа вэ?

-Төгрөгийн ханш чангарч, гадаад валютын ханш суларч байгаатай холбоотойгоор иргэд, байгууллагууд валютын хадгаламжаа төгрөг рүү шилжүүлэх үйл явц өрнөж байгаатай холбоотой. Мөн үүний нөгөө талд валютын хадгаламжийн төгрөгөөр илэрхийлэгдэж байгаа дүн нь багасч байгаа. Үүнтэй холбоотойгоор валютын хадгаламж буурч байна.

-Ам.долларын ханш эргээд чангарч эхэллээ. Алгуур буурч байсан ханш яагаад эргээд өсөх болов?

Мөнгөний бодлогын хэлтсийн захирал Н.Ургамалсүвд:

-Та бүхний мэдэж байгаачлан сонгуулийн өмнөх үеэс эхлээд ам.долларын ханш чангарч, төгрөгийн ханш суларч эхэлсэн. Энэ нь зах зээл дээр богино хугацаанд үүссэн тодорхой бус байдал болон хүлээлттэй холбоотой. Ялангуяа сонгуулийн дараагаас эхлэн ам.долларын ханш чангарах нь гэх хүлээлт үүссэн. Гэтэл бодит байдалд манай валютын орох урсгал маань гарах урсгалаасаа их байгаа. Тэгэхээр макро суурь хүчин зүйлтэйгээ харьцуулж үзвэл төгрөгийн ханш сулрах нөхцөл үүсээгүй гэж харж байна. Тийм учраас энэ байдал алгуур засагдах байх. Нөгөөтэйгүүр төлбөрийн тэнцлийн статистикийг харвал нийт төлбөрийн тэнцлийн алдагдал буурсан. Мөн хөрөнгө, санхүүгийн данс ашигтай гарсан. Төлбөрийн тэнцэл дээр гарч байгаа эерэг үзүүлэлт цаашид хадгалагдана гэж харж байна.



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

2017 оны 6 дугаар сар

Зураг 1. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа



Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



- M2 мөнгөний жилийн өсөлт 20.3% -д хүрч 13.5 их наяд ₮ болов.
- Тухайн сард M2 мөнгө 3.9%-иар (510.6 тэрбум ₮) өсөв.
- Үүнд M1 мөнгө 9.9% (242.1 тэрбум ₮), бусад хадгаламж 2.6% (268.4 тэрбум ₮) -иар өссөн нь нөлөөлөв.
- M1-Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 28.6 тэрбум, төгрөгийн харилцах 213.5 тэрбум ₮-р өсөв.
- Бусад хадгаламж, харилцах-Төгрөгийн хадгаламж 288.9 тэрбум ₮-р өсч, валютын харилцах, хадгаламж 20.4 тэрбум ₮-р буурав.

Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, тэрбум ₮



Зураг 4. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)




- М2 мөнгөний 53.0% буюу 7.2 их наяд ₮-ийг төгрөгийн хадгаламж, 17.3% буюу 2.3 их наяд төгрөгийг валютын хадгаламж бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн 64.1%-ийг иргэдийн төгрөгийн хадгаламж, 19.5%-ийг иргэдийн валютын хадгаламж бүрдүүлж байна.
- Гадаад валютын хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 2017 он гарснаас хойш буурсаар байна. Энэ нь сүүлийн саруудад төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн чангаралттай холбоотойгоор гадаад валютаас төгрөг рүү шилжих шилжилт болон валютын хадгаламжийн төгрөгөөр илэрхийлэгдэх дүн буурч байгаатай холбоотой байна.

Зураг 5. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 6. Банкуудын зээл, голлох салбаруудаар




- Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 872.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 12.9 их наяд төгрөг болжээ.
- Үүнд, иргэдийн зээл 839.2 тэрбум төгрөг 15.9 хувиар өссөн нь нөлөөлжээ.
- Нийт зээлийн үлдэгдлийн 51.5 хувийг хувийн хэвшилд, 47.5 хувийг иргэдэд, 1.1 хувийг бусад салбарт олгосон зээл байна.

Зураг 7. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл




- Нийт зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 1.1 нэгж хувиар буурч 6.2 хувьд хүрчээ. Харин чанаргүй зээлийн хувь өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурч 8.8 хувьд хүрэв.
- Хугацаа хэтэрсэн зээлийн 82.1 хувь, чанаргүй зээлийн 80.4 хувь нь хувийн хэвшилд олгосон зээл байна.

Зураг 8. Ипотекийн зээлийн үлдэгдэл, эх үүсвэрээр



Зураг 9. Тухайн сард олгосон болон төлөгдсөн ипотекийн зээл, тэрбум ₮



- Нийт ипотекийн зээл 4177.2 тэрбум ₮-т хүрснээр чанаргүй зээл 1.8%,
- Хугацаа хэтэрсэн зээл 1.8% байна.
- Нийт ипотекийн зээлдэгчдийн тоо өмнөх сард 1105 зээлдэгчээр нэмэгдэж 91916-д хүрсэн байна,
- Шинээр олгосон зээлийн 57.0 хувь буюу 41.8 тэрбум ₮ нь хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл байна.

Зураг 10. Зээлийн жигнэсэн дундаж хүү



Зураг 11. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү




- Тухайн сард төгрөгөөр олгосон зээлийн хүү 20.3% байгаа бол үлдэгдэлд тооцсон ЖДХ 0.5 нэгж хувиар буурч 18.3% -д хүрчээ. Тайлант сард олгосон валютын зээлийн хүү 0.5 нэгж хувиар өсч 12.5%-д хүрсэн бол үлдэгдлээр жигнэсэн валютын зээлийн хүү нь бага зэрэг буурч 11.6% болжээ.

- Тайлант сард төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээрх жигнэсэн дундаж хүү өмнөх сараас 0.7 нэгж хувиар буурч 12.1%-д хүрсэн бол тухайн сард татсан хадгаламжийн хүү мөн 0.7 нэгж хувиар буурч 12.5%-д хүрчээ. Гадаад валютын хадгаламжийн хүү бага зэрэг буурч 5.6%-д хүрсэн бол тухайн сард татсан валютын хадгаламжийнх огцом буурч 4.3% болжээ.


Зураг 12. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100



Зураг 13¹. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар*



Зураг 14. Худалдааны тэнцэл, сая ам.доллар*




- Урсгал ба хөрөнгийн данс 2017 оны эхний 5 сарын байдлаар 2.5 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 101 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 63 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр буурсан. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -162 сая ам.доллар байна.
- 2016 оны эхний 5 сарын гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 389 сая ам.доллараар буурч, санхүүгийн дансны ашиг 469 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.
- Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны эхний 5 сарын гүйцэтгэлтэй харьцуулахад 31% -иар өсч 3,887 сая ам.долларт хүрсэн бөгөөд барааны худалдааны тэнцэл 834 сая ам.долларт хүрсэн байна.
- Үүнд, чулуун нүүрсний экспорт өмнөх оны эхний 5 сарын гүйцэтгэлээс 796 сая ам.доллараар (45%), төмрийн хүдэр, баяжмалын экспорт 76 сая ам.доллараар (4%), машин, механик тоног төхөөрөмж, эд ангийн импорт 146 сая ам.доллараар (12%), нефтийн импорт 134 сая ам.доллараар (11%) тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

¹ *Эхний 5 сарын гүйцэтгэл

Мөнгөний бодлогын шилжих механизм

Мөнгөний бодлогын үйл ажиллагаа нь мөнгөний бодлогын шилжих механизмаар дамжин эцсийн зорилгодоо хүрч хэрэгждэг. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогын хэрэгсэлд гарсан өөрчлөлт нь ямар сувгуудаар дамжин бодлогын эцсийн зорилгодоо нөлөөлж байгааг мөнгөний бодлогын шилжих механизм илэрхийлнэ.



Бодлогын хэрэгсэлд гарсан өөрчлөлт нь үйл ажиллагааны зорилтоор дамжин банкны болон санхүүгийн зах зээлийн хүүний түвшин, (ипотекийн болон хадгаламжийн), олон нийтийн эдийн засгийн хэтийн төлөвийн талаархи хүлээлт, хөрөнгийн үнэ, валютын ханш; улмаар хувь хүн болон пүүсийн зардал, хадгаламж болон хөрөнгө оруулалтын үйл хөдлөлд нөлөөлдөг.

ОРОН НУТАГТ ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭВ

Монголбанкнаас орон нутаг дахь ипотекийн зээлийн санхүүжилтийг дэмжих зорилгоор хоёр арга хэмжээ аваад байна. Тодруулбал, эхний ээлжинд энэ оны дөрөвдүгээр сард зөвхөн орон нутаг дахь хүсэлтүүдэд зориулж, 15.9 тэрбум төгрөгийг шийдэв. Мөн цаашид сар бүр банкуудад олгох ипотекийн санхүүжилтийн 25 хувийг орон нутагт хуваарилж байх чиглэлийг арилжааны банкуудад өгөв.

2017 онд Засгийн газрын төсвөөс 111 тэрбум төгрөгийг ипотекийн санхүүжилтэд төсөвлөсөн билээ. Энэ дагуу тавдугаар сараас эхлэн ипотекийн зээлийг Монголбанк болон Засгийн газар хамтран санхүүжүүлдэг болоод байна. Тодруулбал, тавдугаар сард Монголбанкнаас 16 тэрбум, улсын төсвөөс 35 тэрбум төгрөг, нийтдээ 51 тэрбум төгрөгөөр ипотекийн зээлийн санхүүжилт хийсэн байна. Цаашид Монголбанкнаас сар бүр санхүүжүүлж буй 16 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийн 25 хувийг хөдөө орон нутагт олгоно гэж тооцвол сард дунджаар 4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэхээр байна.

Тав болон зургаадугаар сард Засгийн газар, Монголбанк хамтран нийтдээ 84 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт гаргаж, 1200 гаруй зээлдэгчийг ипотекийн зээлд шинээр хамрууллаа. Үүнийг задалж үзвэл:

Ипотекийн санхүүжилт /5, 6-р сар/

	Монголбанк	Зээлдэгчийн тоо	Засгийн газар	Зээлдэгчийн тоо
5 дугаар сар	16,024,300,953.00	267	34,937,423,249.00	461
6 дугаар сар	15,969,006,975.00	245	18,078,978,813.00	300
Нийт	31,993,307,928.00	512.00	53,016,402,062.00	761.00

Энэ он гарсаар хөдөө орон нутагт ипотекийн зээлийн шалгуур хангасан ч эх үүсвэргүйн улмаас 17.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хүлээгдэж байсан юм. Дөрөвдүгээр сард 15.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээрээ нийт хүлээгдэж байсан хүсэлтийн 90 орчим хувийг шийдвэрлэлээ.

Харин тавдугаар сард хөдөө орон нутагт 6.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хуваарилагдав. Ингэхдээ 1 тэрбум төгрөгөөс доош хэмжээтэй санхүүжилтийг бүрэн шийдвэрлэлээ. Харин Дархан-Уул аймагт дахь 2.7 тэрбум төгрөгийн хүсэлтээс 2.5 тэрбум төгрөгийг, Орхон аймаг дахь 3 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус шийдвэрлэв.

Энэхүү авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хэрхэн гарч буй талаар Монголбанк тухай бүрт нь хяналт тавин ажиллаж, арилжааны банкуудаас урьдчилсан байдлаар мэдээллийг байнга авч байна. Мэдээллээс харахад хөдөө орон нутагт шийдвэрлэгдэж байгаа ипотекийн зээлийн хэмжээ 4, 5-р сард өмнөхөөс хоёр дахин нэмэгдсэн байна. 2017 оны нэг, хоёрдугаар сард орон нутагт нийтдээ дунджаар 50 орчим зээл шийдэгдэж байсан бол 4-р сард 100 орчим, 5-р сард 220 орчим зээлдэгчийн хүсэлтийг бүрэн шийдвэрлэв.



ЭДИЙН ЗАСАГЧИД ЯМАР ХЭРЭГТЭЙ ВЭ?

Эдийн засагчид яг ямар хэрэгтэй вэ гэдэг талаар Нобелийн шагналт эдийн засагч Роберт Шилерийн бичсэн нийтлэлийг орчуулан хүргэж байна

2007-2009 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш эдийн засагчдыг их хурц шүүмжлэх болсон. Нөлөө нь одоо хүртэл үргэлжилсээр байгаа тэрхүү явдлыг ихэнх эдийн засагчид урьдчилж харж чадаагүй. Энэ нь олон хүнийг эдийн засгийн мэргэжил нийгэмд ямар нэг чухал хувь нэмэр оруулдаг эсэхэд эргэлзэхэд хүргэсэн. Хүмүүсийн сайн сайхан амьдралд онцгой нөлөөтэй ийм зүйлийг л урьдчилан харж, анхааруулахгүй юм бол эдийн засагчид ер нь ямар хэрэгтэй юм бэ?

Нээрээ ч эдийн засагчид 1920-2021 оны уналт, 1980-1982 оны дараалсан эдийн засгийн уналт, 1929 оны хувьцааны зах зээлийн уналтыг залгасан их хямрал гэх мэт түүхэн дэх ихэнх том хямралуудыг урьдчилан харж чадаагүй. Эдгээр хямралуудын өмнөх жилийн архивын мэдээнээс хайж үзэхэд хүчтэй хямрал ирж буйг анхааруулсан эдийн засагч байсангүй. Харин, нэлээд

өөдрөг хандлага давамгайлсан улстөрч, бизнесийнхний үзэл бодлыг сонинууд түлхүү түгээж байж.

Жинхэнэ анхааруулга гэж хэлэхэд хамгийн ойрхон зүйл 1980-1982 оны уналтын өмнө л гарч иржээ. 1979 онд Холбооны Нөөцийн Банкны тэргүүн Пол Волкер эдийн засгийн таагүй нөхцөл байдалтай АНУ тулгараад байгааг хэлээд хэцүү шийдвэр, хязгаарлалт, бүр золиос ч хийх хэрэгтэй байгааг анхааруулж байв. 1979 оны газрын тосны хямралын үр нөлөө арилаагүй байхад өндөр инфляцитай тэмцэхийн тулд хийгдэх огцом алхам нэмэгдэхээр ноцтой эдийн засгийн уналт үүсэхээр байж.

Гэлээ ч өнгөрсөн зуунд хямрал ойртох болгонд эдийн засагчид арай өөр байр суурь илэрхийлж байв. Миний олж мэдсэнээр Жон Кейнз, Фредрик Хайк эсвэл

Ирвинг Фишер мэтийн одууд хүртэл Их хямрал ирж буй талаар олон нийтэд хандсан зүйл яриагүй байдаг.

Түүхч Дуглас Ирвиний баримтжуулснаар бол Шведийн эдийн засагч Густав Кассел л ганц сондгой тохиолдол байв. Тэрээр 1928 онд Колумбийн их сургууль дээр тавьсан цуврал лекцүүддээ дэлхийг хамрах үргэлжилсэн эдийн засгийн уналт болохыг анхааруулж байжээ. Гэхдээ түүний онолын талдаа яриа нь (мөнгөний онол болон алтан стандартад төвлөрсөн) эдийн засагчдын дунд нэгдсэн шинэ байр суурийг бий болгоогүй ба сонин медиа ч тодорхой сэрэмжлүүлэх мэдээлэл хүргээгүй юм. Сонирхолтой нь, тухайн үеийн мэдээн дунд 1929 оны сүйрлийн дараа олон нийтийн зүгээс эдийн засагчдад уур бухимдлаа илэрхийлсэн баримт бараг байсангүй. Тэгвэл яагаад сүүлийн (2008 оны) хямралыг урьдчилж харж чадаагүй нь эдийн засгийн мэргэжлийнхний талаарх хандлагыг ингэж өөрчлөв? Эдийн засагчдад үл итгэх байдал урьд нь алдахад нь байгаагүй хэрнээ яагаад гэнэт ихээр бий болов?

Нэг шалтгаан нь олон эдийн засагч их л итгэлтэйгээр сурталчилж байсан нөгөө үр ашигтай зах зээл нь хувьцаа, хөрөнгийн үнийн уналтыг үүсгэсэн гол зүйл байснаас болсон байж магад. Зах зээл үргэлж хамгийн сайн мэдэж байдаг гэж тэд итгэцгээн хувьцаа ба байрны үнийн хөөрөгдлийн талаарх зарим нэгний (миний ч бас) анхааруулгыг үл ойшоосон. Ингээд аль алиных нь үнэ огцом унахад эдийн засагчийн нэр хүндэд шууд цохилт болсон юм.

Гэхдээ үүнээс болж эдийн засагчид ямар хэрэгтэй юм гэж шүүмжлэх нь шударга бус хэрэг. Бид эмч нарыг бүх өвчнийг маань урьдчилж мэдсэнгүй гэж буруутгадаггүй. Бие муудах нь гэнэтийн тохиолдол байх нь их бөгөөд эмч нар ирэх жил бид ямар өвчин тусахыг хэлж мэддэггүй, өвдлөө ч бүх өвчнийг анагаадаггүй. Гэсэн ч эмч нарын үзүүлдэг тус биднийг баяртай л байлгадаг. Ихэнх эдийн засагчид хувьцааны зах зээл эсвэл ажилгүйдлийн түвшний төлөв байдлыг тодорхойлохоос нэлээд өөр зүйлд гол хүчин чармайлтаа зарцуулдаг. Тиймээс бид хийсэн зүйлд нь л талархалтай байх хэрэгтэй юм.

“Триллион долларын эдийн засагчид” (Trillion Dollar Economists) номондоо Брукингс Институтийн Роберт Литан эдийн засгийн мэргэжил триллион долларын орлого, эд баялгийг АНУ болон дэлхийн бусад орнуудад

авчирсан тухай бичдэг. Энгийн тооцоо хийгээд үзэхэд л харьцангуй жижиг мэргэжлийн хувьд энэ нь дажгүй хувь нэмэр шиг сонсогдоно. Жишээ нь, 20 мянган гишүүнтэй Америкийн Эдийн засгийн Холбоо (би ерөнхийлөгчөөр нь ажиллаж буй) 2 триллион долларын орлого, эд баялгийг бий болгосон гэж үзвэл, энэ нь хүний 100 сая доллар болно.


Тэгвэл эдийн засагчид тийм л ухаантай юм бол яагаад хамгийн баян хүмүүс биш байна гэж асуух байх. Хариулт нь их энгийн: Эдийн засгийн ихэнх санаанууд патент авдаггүй нийтийн бараа эсвэл зохиогч нь л өөрөө эзэмшдэг зүйл байдаг. Тэгэхээр эдийн засагчид өөрсдөө баян биш байлаа ч тэдний санаа бусад олон хүмүүсийг баян болгохгүй гэсэн үг биш юм.

Бизнесээ хэрхэн удирдах эсвэл эдийн засгаа хэрхэн авч явах талаар олон ухаалаг санааг багтаасан нь Литаны номны сонирхолтой тал нь. Эдгээр дотор үнийг оновчтой болгох, маркетингийн механизм, монополийн зохицуулалт, байгалийн баялгийн удирдлага, нийтийн барааны түгээлт, санхүү гэсэн олон салбарыг хамарсан санаанууд бий. Аль нь ч триллион долларын үнэ хүрэхгүй ч, бүгдийг нь нийлүүлвэл Литаны дүгнэлт үнэмшилтэй байж болохоор.

2010 онд гарсан “Эдийн засгийн ухаанаар амьдралаа сайжруулах нь” (Better Living through Economics) номонд CO2 ялгаруулах эрхийн наймаа, орлогын татварын буцаалт, худалдааны тарифийн хөнгөлөлт, ажил эрхлэлтийг дэмжих халамжийн програм, илүү үр дүнтэй мөнгөний бодлого, эфирээр шууд дамжуулах эрхийн дуудлага худалдаа, тээврийн салбарын зохицуулалт, монополийн эсрэг сайжруулсан бодлого, сайн дурын цэрэг, тэтгэврийн хадгаламжийг нэмэгдүүлэх дефолт опцион гэх мэт шинэ зүйлсийн бодит ертөнцөд үзүүлэх нөлөөг онцолдог.

Тэгвэл эдгээр номуудад тайлбарласан инновациудаас харахад эдийн засгийн мэргэжил их хэмжээний, маш үнэ цэнэтэй ажлуудыг бий болгосон нь харагдана. Тэр ажлуудыг нэлээд нухацтай зүтгэл чармайлтын үр дүнд гарч ирсэн онцгой баримт нотолгоонууд тодорхойлно. Тийм ээ, ихэнх эдийн засагчид санхүүгийн хямралуудыг урьдчилан тааж чаддаггүй яг л эмч нар өвчнийг урьдчилж мэддэггүй шиг. Гэхдээ тэд яг л эмч нар шиг амьдралыг илэрхий сайжруулсан гэж хэлж болно.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 26/VII ӨДРИЙН БАЙДЛААР)**



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ОЧИРДАРА ЖАВЗАНДАМБА ЛАМЫН АЛТАН ТАМГА

Хосгүй үнэт

1915 он

Жин: 6666 гр

Өндөр 9 см, 10.5 x 10.5 см, зузаан 3.2 см

Тамганы гол хэсэгт соёмбо ба хоёр хажуугаар нь монгол болон түвэд үсгээр "Зарлигаар өргөмжлөгдсөн шашныг мандуулах, амьтныг жаргуулагч аврал итгэл хамгийг айлдагч, оройн чандмань Очирдара Жавзандамба ламын тамга" гэж бичжээ. Мөн тамганы бариулын хоёр талд "Олноо өргөгдсөний тавдугаар он, Дотоод хэргийг хавсарсан ёслолын яамнаа үйлдэв" гэсэн бичигтэй бөгөөд бариулыг бурхан багшийн бие хэл сэтгэлийг бэлгэдсэн чандмань эрдэнээр урласан байна.





Д.ТӨМӨРХҮҮ: ХАРИЛЦАГЧИДДАА ТӨВӨГТЭЙ БАЙДЛЫГ ҮҮСГЭХГҮЙ БАЙХ НЬ МАНАЙ ГОЛ ЗОРИЛГО

"Ариг" банкны Гүйцэтгэх захирал Д.Төмөрхүүтэй ярилцлаа.

► **Та 2006 оноос хойш "Ариг" банкинд Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа юм байна. Тухайн үед "Эрэл" нэртэй байсан. Тэр үеийн "Эрэл" банк, одоогийн "Ариг" банкны хоорондын ялгааг товчхон дурьдана уу?**

2006 он гэхээр зөвхөн "Эрэл" эсвэл "Ариг" банк ээрэг аль нэг байгууллагаас гадна Монгол Улс өөрөө маш их өөрчлөгдсөн. Эдийн засгийн хувьд, хэрэглэгчид, харилцагчдын хүлээлт, хүсэлт шаардлагын хувьд ч маш өөр болсон. "Ариг" банкны олон жилийн өмнөөс урдаа тавьж ирсэн зорилго бол харилцагчдын хүсэл, шаардлагад хамгийн өндөр ач холбогдлыг өгөх. Ер нь байгууллага, бизнес юун дээр тогтдог вэ. Байгууллага гэдэг зүйлийг хэн тэтгэж, асарч, халамжилж явдаг юм бэ гэдэг асуултыг бид өөрсөддөө тавьдаг. Энэ нь үйлчлүүлэгч, харилцагч. Хэрвээ үйлчлүүлэгч, харилцагч өөрийг чинь сонгоод, бүтээгдэхүүн, үйлчилгээг чинь аваад, орлого оруулахгүй бол аль ч байгууллага үүдээ барина. Тийм учраас харилцагчдын хүссэн зүйлийг шинээр бүтээж, эрэлхийлж, одоо явж байгаа процесс маань нүдээ олоогүй, харилцагчдад төвөгтэй байвал тэрийг аль болох шуурхай засч, залруулах ёстой гэж үздэг. Тийм учраас "Ариг" банкны "Утсаар халамжлах

төв" маань долоо хоногийн долоон өдөр 24 цагийн турш ажиллаж байна. Мөн технологийг ашиглаад заавал харилцагчиддаа банкны биет байршил руу явуулахгүйгээр үйлчилгээг аль болох хялбар хүргэх талаар анхаарч ажиллаж байгаа. Манай стратегийн бас нэг чухал зүйл бол тогтвортой хөгжил. Өнөөдөр бид анхаарал хандуулах ёстой нийгмийн олон асуудал байна. Тиймээс бид маркетингийн сул гэж харж болох зардлуудыг нийгэм рүү чиглэсэн, байгаль орчныг хамгаалах ажлуудыг дэмжих, Монголын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахад зарцуулдаг.

► **"Ариг" банк жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр түлхүү үйл ажиллагаа явуулдаг. Тиймээс Монголын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа зовлон, бэрхшээл, ЖДҮ-ийн өнөөгийн хөгжлийн талаар та тодорхой хэмжээнд ойлголттой байгаа байх. ЖДҮ-ийн өнөөгийн хөгжлийг та хэрхэн харж байна вэ?**

Манай зээлдэгчдийн дийлэнх хувийг бичил бөгөөд жижиг бизнесүүд бүрдүүлдэг. Дунд бизнес ч цөөн. Тэгэхээр бид жижиг бизнесүүдийн онцлог, зовлон, жаргал, шаардлагатай ойр байдаг. Монголд буюу хөгжлийнх нь үе шат Монголтой ижил төстэй түвшинд

АРИГ БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ТӨМӨРХҮҮ

АЖЛЫН ТУРШЛАГА:

1998-2002: АНУ, Нью-Йорк хот-"Wiechert/dj real estate"-Ул хөдлөх хөрөнгийн шинжээч
2002-2004: АНУ, Бостон хот-"Smith Barnley, Citigroup"-Санхүүгийн зөвлөх
2004-2005: АНУ, Бостон хот, Wainwright банк
-Үйлчилгээ хариуцсан менежер
2005-2006: "Ариг" Банк-Ахлах эдийн засагч
2006 оноос: "Ариг" банк Манлай дэмжигч
/Гүйцэтгэх захирал/

БОЛОВСРОЛ:

1992-1995: Улаанбаатар хот, Отгонтэнгэр их сургууль-Бакалавр, Англи хэлний орчуулагч багш
2003-2005: АНУ, Нью-Йорк хот, Pace их сургууль-Магистр, Санхүүгийн удирдлага

яваа тогтворгүй бодлоготой, төрийн зохицуулалт, үйлчилгээ сул улс орнуудад бизнес эрхлэнэ гэдэг үнэхээр их тэвчээр, чадал, туршлага, уран ухаан, бүгдийг хослуулж байж хийх зүйл. Жижиг бизнес эрхлэгчдийн хувьд өөрсдийнхөө хүсч байгаа зээлийн хэмжээнд барьцаа хөрөнгө төдийлөн байдаггүй. Тийм учраас хийе гэсэн ажлаа бүрэн хэмжээнд хийж чадахгүй байх тохиолдлууд бий. Үүнийг шийдэх нэг арга бол зээлийн оноо. Хүн бүр, бизнес болгон өөрийн гэсэн "зээлжих оноо"-той байна. Энэ бол шинэ зүйл биш, олон улсад бол стандарт болсон зүйл. Хүн бүр "зээлжих оноо"-гоороо дамжуулан заавал барьцаа хөрөнгө гэлгүйгээр өөрийгөө итгэлтэй хүн гэдгийг харуулах боломжтой. Энэ орчныг бүрдүүлж чадвал жижиг, дунд бизнесүүдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд маш том алхам болно.

► **Та өмнө нь АНУ-ын банкны салбарт ажиллаж байсан юм билээ. Мэдээж, Америк болон Монголын банкны салбарын хөгжил маш их ялгаатай байгаа байх. Гэхдээ Монголын банкны салбар Америк, тэр дундаа олон улсын түвшинд хүрч хөгжих боломжтой. Тэр цаг хугацааг та хэр ойрхон гэж хардаг вэ?**

Хоёр улсын эдийн засаг, санхүүгийн системийг харьцуулахаас өмнө тухайн хоёр эдийн засгаа харьцуулах хэрэгтэй. Нэгдүгээрт, насжилтын ялгаа

байна. Манай улс нээлттэй эдийн засгийн систем рүү шилжээд удаагүй байна. Гэтэл Америкийн чөлөөт эдийн засгийн системийн насжилт манайхаас хамаагүй ах, олон жилийн туршлагатай. Хоёрдугаарт, ялангуяа арилжааны банк болон жижиглэнгийн (retail) зах зээлийн талаар гэвэл зах зээлийн багтаамж, хэмжээний асуудал бий. Суурь ялгаанууд гэвэл иймэрхүү. Яахав, системийн ялгааны хувьд Монголд байх шаардлагатай, байгаасай гэж боддог байсан зүйлүүд эхнээсээ бий болж байна. Үүнд миний хувьд бол гурван гол зүйл байгаа юм. Нэгдүгээрт, хадгаламжийн даатгалын тогтолцоо. Саяхнаас байгуулагдаад, ажиллаад эхэллээ. Энэ бол иргэдийн банкны системд итгэх итгэлийг нэмэгдүүлэх маш сайн зүйл. Хоёрдугаарт, түрүүн хэлсэнчлэн зээлийн онооны систем. Энэ системийг сайн хийж чадвал үүгээр дамжаад санхүүгийн хариуцлага тэс өөр түвшинд очих боломжтой. Монголын Банкны Холбоо, арилжааны банкуудтайгаа хамтраад "Зээлийн мэдээллийн төв" гэж байгууллагыг үүсгэн байгуулаад,



ажиллуулах бүх бэлтгэл ажлыг хийсэн. Одоо тусгай зөвшөөрөл л авах дутуу байна. Гуравдугаарт, орлого баталгаажуулалт. Ингэхдээ тухайн улс орныхоо татварын албаар баталгаажсан мэдээлэлд үндэслэн зээл олгох эсэх, зээлийн хэмжээ их үү, бага уу гэдгийг шийддэг. Бид ийм тогтолцоонд шилжиж чадвал харилцагчдад ч, санхүүгийн байгууллагуудад ч маш амар болно. Цаашлаад зээлийн хүүгийн зардал ч буурах боломжтой. Ийм гурван ялгаа ажиглагддаг. Гэхдээ манай улс Америк ч юм уу, бусад улс орнуудын өнөөдрийн түвшиндээ хүрэхэд зарцуулсан хугацаанаас хамаагүй богино хугацаанд ижил хэмжээнд хүрч очих боломжтой гэж хардаг. Гагцхүү үүн дээр бид зорилгын хувьд төвлөрөөд, бодлогоо зөв тодорхойлж, тууштай байж чадвал маш богино хугацаанд хийж чадна.

► **Монголын банкны салбарын өнөөгийн нөхцөл байдлыг та хэрхэн үнэлэх вэ. Мэдээж банкны салбар эдийн засгийн хүндрэл, хямралтай хүнд хэцүү он**

жилүүдийг туулж байна. Чанаргүй зээлийн хувь хэмжээ нэмэгдэхээс эхлээд эдийн засгийн хүндрэл санхүүгийн секторт тусгалаа олж эхэлснийг эдийн засагчид хэлж байгаа. Одоо нөхцөл байдал ямар байна вэ?

2012-2016 онд эдийн засгийн хямралыг туулаад ирлээ. Гэхдээ яг одоогийн байдлаар эдийн засагт сэргэлт ажиглагдаж эхэлж байна. 2016 оны эцэст 1 хувийн эдийн засгийн өсөлттэй байсан. Харин 2017 оны нэгдүгээр улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 4.2 хувьд хүрсэн. Гол түүхий эдийн үнэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 50 орчим хувиар өсөөд байна. Мөн гадаад худалдаан дээр үнийн нөхцөлүүдийг дунджаар 15 хувиар сайжруулж чадлаа. Тэгэхээр эдийн засаг маань эргээд сэргэх нөхцөл рүүгээ орсон гэх дүгнэлт байна. Энэ нь эргээд банкны систем дээр бас зээлийн чанар дээр ч үр дүнгээ өгөх нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, хямралаас гарах эргэлтийн үе шатанд явж байна.

► **Чанаргүй зээлийг шийдвэрлэх хүрээнд Монголбанкнаас Активын удирдлагын хуулийн төслийг боловсруулж, Актив удирдлагын компанийг байгуулах нь зөв гэж үзэж байгаа. Та энэ талаар ямар байр суурьтай байдаг вэ. Активын удирдлагын компани Монголд ажиллах шаардлагатай юу?**

Активын удирдлагын компани ихэнх улс оронд маш олон жилийн өмнөөс бий болж, системийнх нь заавал байх ёстой, салшгүй нэг хэсэг нь болчихсон байдаг. Монголын банк, санхүүгийн системд зөв засаглалтай, бүрэн гүйцэд хөгжсөн байхын тулд активын удирдлагын компани зайлшгүй байх ёстой. Банкууд одоо бол тусгай активтай холбоотой бүх ажлыг өөрсдөө хийдэг. Үндсэн үйл ажиллагаанаас хороож байгаа цаг, нөөц бололцоо бүхэн бүтээмж, зардалд нөлөөлж байна. Гэтэл олон улсын түвшинд тусгай активтай ажиллах, зээл барагдуулах зэрэг асуудлыг хариуцдаг тусгай компани, мэргэшсэн байгууллагууд бий. Банкуудын хувьд мэдээж сонголт нь өөрсдөд нь бий. Өөрсдийнхөө хүчээр тусгай активаа шийдэх үү, эсвэл мэргэшсэн байгууллагад өгч, өөрийн хамгийн сайн хийж чаддаг ажилдаа тэрхүү цаг, нөөц бололцоог зориулах уу гэдэг. Активын удирдлагын компаниудад хууль эрх зүйн тусгай нөхцөлийг бий болгож өгсөн байдаг. Тэгж байж, активын удирдлагын компани байгуулах эдийн засгийн сонирхлыг өдөөдөг. Монголын нөхцөлд банкууд чанаргүй зээлээ шийдэхийн тулд маш олон жилийн үйл явц шаардагддаг. Шүүхийн шат дамжлага, шүүхийн шийдвэр хэрэгжүүлэх гэх зэрэг үйл ажиллагаа багадаа 2-3 жил. Бүр цаашилбал, шийдэгдэхгүй 10 жил болчихсон ч зээлүүд банкуудад байдаг. Активын удирдлагын системтэй улсын банкуудын чанаргүй зээлийн үзүүлэлт бага байх тохиолдлууд бий. Банкууд тохирсон үнээр нь чанаргүй зээлээ мэргэжлийн компаниудад зардаг. Ингээд өөр өөрсдийн мэргэшсэн, хамгийн сайн чаддаг ажлаа хийгээд явах бололцоо бүрддэг.

► **Эдийн засгийн нөхцөл байдлын талаар цөөн хэдэн асуулт асууя. Мэдээж, хамгийн түрүүнд Монгол Улс ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдахаар болсон. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр эдийн засагт “ногоон гэрэл” аслаа гэж албаныхан дүгнэж байгаа. Та хэрхэн дүгнэж байна вэ?**

Улсынхаа хэмжээнд маш эгзэгтэй, санаа зовоосон үед ОУВС-гийн хөтөлбөр орж ирсэн. Улс маань эргэн

төлөгдөх ёстой өрүүдээ төлөх чадваргүй болсон үед орж ирсэнийг ярьж байна. Нөгөөтэйгүүр ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжсэнээрээ бүх зүйл сайхан болчихно гэж ойлгож болохгүй. Ялангуяа богино хугацаанд бүс чангалсан, амаргүй байдал үүсэхийг үгүйсгэх аргагүй. Гэхдээ дунд болон урт хугацааны том зургаар нь харвал тогтвортой байдал үүсч чадаж байвал маш чухал. Улсынхаа хэмжээнд зардлын сайн удирдлагатай, ялангуяа төсвийн сахилга баттай байна гэдэг бидэнд үгүйлэгдэж байсан зүйл. Тэгэхээр энэ агуулгаараа хөтөлбөр нь сайн талтай гэж харж байгаа. Тэгэхээр энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Монголынхоо эдийн засаг, нөхцөл байдалд тохируулсан байдлаар хэрэгжүүлж чадвал, мөн үүнээсээ суралцаад цаашдаа хөтөлбөр дууссаны дараа засаглал сайтай явж чадвал маш хэрэгцээтэй зүйл болно. Хөтөлбөр дууссаны дараа хэрхэх вэ гэдэг нь Монголчууд бидний, тэр дотроо төр баригчдын хариуцлагаас хамаарах асуудал.

► **ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд банкуудад Активын чанарын үнэлгээ хийхээр болсон. Таны бодлоор банкууд энэ үнэлгээнд бэлэн байна уу?**

Урьд өмнө нь активын чанарын үнэлгээ хийгдсэн улс орнуудыг харахад тухайн улс орныхоо эдийн засаг, Төв банк, санхүүгийн системийн онцлог, хөгжлийн үе шаттай уялдаж хийгдэх нь зөв байдаг юм байна. Тэгэхээр манай улсын хувьд ч бас энэхүү үнэлгээ нь улс орныхоо, нийт санхүүгийн системийнхээ, зохицуулалтын орчныхоо, зохицуулагч болон арилжааны банкуудыг хамруулсан банкны системийнхээ нөхцөл байдал, түвшинтэй уялдсан шалгалт байх шаардлагатай. Өндөр хөгжилтэй улс орны, Монголын нөхцөлтэй уялдахгүй шаардлагад тохируулах гэж оролдвол онцлогууд гарч ирнэ. Банк тус бүрийн өмнөөс ярих боломжгүй ч гэсэн Монголын банкуудаас их зөрүүтэй, сөрөг үзүүлэлт гарахгүй болов уу гэж бодож байна.

Ярилцсанд баярлалаа.

БОДЛОГЫН ХҮҮ



Монголбанк Төв банкны 7 хоногийн хугацаатай үнэт цаасны хүүг 2007 оны 7 дугаар сараас бодлогын хүү болгон зарласан.



Монголбанкны бодлогын хүү хөдлөхөд түүнийг дагаад арилжааны банкуудын хадгаламжийн хүү, улмаар зээлийн хүүнд өөрчлөлт орохоор хүлээгддэг.

Монголбанкны бодлогын хүүний өөрчлөлт нь Төв банкнаас баримталж буй мөнгөний бодлого аль чиглэлд /хатуурах, зөөлрөх/ өөрчлөгдөж буйг илтгэхийн сацуу банк хоорондын захын хөтөч хүүний үүргийг гүйцэтгэнэ.

Өөрөөр хэлбэл, банк хоорондын захын арилжааны жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны бодлогын хүүтэй ойролцоо түвшинд тогтохоор хүлээгддэг.





ХҮҮХДҮҮД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ АХУЙГААСАА (ЭЦЭГ ЭХЭЭС) АВЧ БАЙДАГ



"Эрдэм Мэдлэг Түгээх Төв" ТББ-ын
захирал **Л.Ундаргаа**

Сургуулийн орчинд хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох үйл ажиллагаа зөвхөн ахлах ангид бус нэгдүгээр ангиас нь эхлэн бага багаар бодит хэрэглээнд тулгуурлан төлөвшүүлснээр эерэг өөрчлөлтийг харж болно. Тухайлбал сургуулиас гадуурх үйл ажиллагаагаар дэмжин хүүхэд залуучууд хувь хүний хувьд санхүүгийн боловсролыг зохистой хэмжээнд авах болно.

Үүний тулд хамгийн гол анхаарах зүйл нь хэзээ, хаана, хэнд, юуг, хэрхэн, яаж, хэнээр хүргэх вэ? гэдгийг л тодорхой болгох нь чухал. Хэдийгээр агуулга чухал ч хэзээ өгч эхлэх, хэзээ дадлагажуулах, хэрхэн чадавхижуулах вэ? гэдэг хүчин зүйлүүдийг хүн бүр, өрх бүрээр нь тодорхойлсноор санхүүгийн боловсрол олгодог бидний үйл ажиллагааны үр өгөөж өндөр байна. Санхүүгийн хувьд хариуцлагатай, боловсролтой иргэд бий болгоно.

Санхүүгийн боловсролын агуулга нь сургуулийн

хөтөлбөрөөс гадна сургуулиас гадуурх үйл ажиллагаанаас буюу амьдрал ахуйгаас суралцах нь үр дүнтэй болохыг манай сургалтын төвөөс хийсэн судалгааны үзүүлэлтээр харагдаж байсан юм.

Хүүхэд бага наснаасаа эхлэн өөрөө сонголт хийх боломжтой байдаг. Хүүхдийн бага насанд нь эцэг эх, асран хамгаалагчид өмнөөс нь сонголт хийдэг бол хүүхэд нэг нас хүрэхийн өмнөхөн өөрөө тодорхой хэмжээнд сонголтыг хийж эхэлдэг байна. Хүүхэд бага насандаа сонголт хийж сурвал өсч том болох тусам санхүүгийн холбогдолтой шийдвэр гаргаж сурахад хялбар байдаг байна. Хүүхдэд тэдний нас, ахуйн онцлогт тохируулан сонголт хийх чадварыг суулгаснаар тэд юуны өмнө мөнгөний зөв хуваарилалтыг аажмаар ойлгож тэдний ирээдүйн санхүүгийн чадамжид нь эерэгээр нөлөөлнө.

Хувь хүний санхүүгийн боловсрол нь хөгжингүй орны хувьд бага наснаас нь эхлэдэг. Манай орны хувьд


иргэд (насанд хүрэгчид) маань санхүүгийн хүндрэлийг ойлгож мэддэггүйгээсээ болж өөрт байгаа баялгаа ухаалгаар удирдах арга ухааныг хэрэггүй мэтээр бодох нь түгээмэл байсан бол зах зээлд шилжсэнээр эдийн засгийн хямрал, инфляци зэрэг нь амьдралд нь шууд нөлөөлж эхлэснээс хамаараад иргэд, хувийн болон өрхийн санхүүгийн чадамжиндаа санаа тавих болсон.

Бид өрхийн санхүүг хэрхэн удирдах талаар зөвөлгөө өгч олон өрх гэрийг хамруулан ажиллаж ирэхдээ өрхийн гишүүн бүрийн санхүүгийн боловсролд анхаарч ирсэн. Бидний судалгаанаас болон ажиглалтаас харвал хүүхэд нь санхүүгийн шийдвэр гаргах, мөнгөтэй зөв харилцах чадварт аав, ээж, ахуйгаасаа шууд суралцдаг болох нь батлагдсан.

Иймд бидний гол анхаарах зүйл нь хүүхдүүдэд сургуулийн орчинд тусгай хөтөлбөрөөр боловсролыг өгөхөөс гадна, сургуулиас гадуурх үйл ажиллагаагаар болон ахуйн нөхцөлд нь ариувч хямгач байх хандлага, чадварт сургахад ихээхэн анхаарах хэрэгтэй.




ӨРХИЙН САНХҮҮ/ТӨСӨВ



Судалгаанд хамрагдсан ахлах ангийн нийт **3000** сурагчийн:

76% нь өрхийн төсөв хэрхэн зохиох талаар ойлголтгүй байсан.



Судалгаанд хамрагдсан **1600** эцэг эхийн

28% нь хүүхдүүдтэйгээ хамтдаа өрхийн төсөв зохиох оролдлого хийхэд хэцүү байсан гэсэн хариулт өгсөн.



Судалгаанд хамрагдсан **1600** эцэг эхийн

93% нь хүүхдүүд санхүүгийн боловсролыг сургуулийн хөтөлбөрөөр дамжуулж авах нь зохистой гэж үзсэн.

МӨНГӨНИЙ УДИРДЛАГА



Судалгаанд хамрагдсан ахлах ангийн **3000** сурагчийн

75% нь мөнгөний талаар аль болох эрт мэдэхийг хүсч байгаагаа илэрхийлсэн.



МӨНГӨН ТЭМДЭГТИЙН НАСЖИЛТЫН ТУХАЙ

Төв банк нь Монгол Улсын нэрийн өмнөөс гүйлгээн дэх бэлэн мөнгөний эрэлт хэрэгцээнд тулгуурлан мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах онцгой эрх эдэлдэг байгууллага бөгөөд гүйлгээн дэх мөнгөн дэвсгэртийн зохистой бүтцийг бий болгодог.

Монголбанк мөнгөн тэмдэгтийн өнгө үзэмж, эдэлгээ даах чанар, нууцлалын үзүүлэлт зэрэгт онцгой анхаарал тавьж өндөр өртөгтэйгөөр хэвлүүлдэг бөгөөд бохирдож, өнгө үзэмж алдсан дэвсгэртийг хэрэглээнээс татах арга хэмжээг авдаг. Гүйлгээнд байгаа дэвсгэртийн эдэлгээ даах чанар, нууцлал, загвар болон бүтцийн зохистой нийлүүлэлт нь Төв банкны үйл ажиллагааг тодорхойлогч нэг хүчин зүйл болдог бол дэвсгэртийн

бүрэн бүтэн байдал, бохирдолт, гэмтэл зэрэг нь олон нийтийн бэлэн мөнгөтэй харьцах хэвшлийг харуулдаг. Гүйлгээнээс татагдаж, улмаар устгагдаж байгаа дэвсгэрт нь гүйлгээнд байгаа нийт дэвсгэртийн 20-30 хувийг эзэлж байгаа нь дэвсгэртүүдийн нас, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судлах шалтгаан болж байна.

Мөнгөн тэмдэгтийн дундаж насжилт гэдэг нь урагдсан, бохирдсон, нууцлал нь арилсан зэрэг шалтгаанаар гүйлгээнээс татагдаж, устгагдах хүртлэх мөнгөн тэмдэгтийн гүйлгээнд идэвхитэй эргэсэн хугацааг хэлнэ. Мөнгөн тэмдэгтийн дундаж нас нь цаасны чанар, цаг агаарын онцлог, иргэдийн цаасан мөнгөтэй харьцах дадал хэвшил, Төв банкны бодлого, банк санхүүгийн

салбарын хөгжил зэргээс хамаарна. Тиймээс энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын цаасан мөнгөн тэмдэгтийн дундаж насжилт, түүнд нөлөөлөх гол хүчин зүйлүүдэд дүгнэлт хийх явдал юм.

Мөнгөний насжилтын мэдээллийн баазад гүйлгээнд гарсан дэвсгэрт, устгасан мөнгөн дэвсгэртийн мэдээллийг оруулсны үр дүнд мөнгөн дэвсгэрт тус бүрээр дундаж насжилт жилээр тооцоологдон гарч байна.


Хүснэгт 1. Дэвсгэртийн дундаж насжилтыг програмын аргаар тооцсон мэдээлэл

№	Дэвсгэр тийн төрөл	2015.12.31-ний байдлаар			2016.12.31-ний байдлаар		
		Нийт тоо	Түүврийн давтамж	Дундаж насжилт жилээр	Нийт тоо	Түүврийн давтамж	Дундаж насжилт жилээр
1	1	50	4	4.24	50	4	4.24
2	5	50	1	0.29	50	1	0.29
3	10	13,475	8,003	4.76	18,991	11,897	5.13
4	20	15,087	8,286	4.34	21,541	12,591	4.70
5	50	20,537	8,797	3.50	29,665	13,168	3.77
6	100	22,359	17,080	2.83	32,627	25,701	3.07
7	500	22,417	16,455	2.96	32,902	25,028	3.24
8	1000	24,380	18,762	2.48	36,841	29,610	2.66
9	5000	24,040	17,445	4.20	38,875	29,867	4.56
10	10000	22,850	10,786	5.16	37,504	19,374	5.64
11	20000	20,191	11,925	4.88	32,977	20,962	5.39
Нийт тоо Дундаж нас		185,436	117,544	3.60	282,023	188,203	3.88

Устгагдаж буй дэвсгэртийн бүтцээс харахад 1-т, 5-т, 10-т болон 20-тын дэвсгэртүүд устгалд бага ордог. Дэвсгэртүүдийн үнэ харилцан адилгүй байдаг нь тухайн дэвсгэртийн хэмжээ, хэдэн төрлийн нууцлал байгаагаас шалтгаалдаг. Жижиг дэвсгэртүүд хэмжээ бага, цөөн тооны нууцлалтай тул харьцангуй бага үнэтэй байхад, дунд болон том дэвсгэртүүд хуурамчаар хийх эрсдэл их байдаг тул олон төрлийн нууцлалтай, дэвсгэртүүдийн

үйлдвэрлэлийн өртөг өндөр байдаг.

Мөнгөн тэмдэгтийн цаасыг нэхмэлийн үйлдвэрт хэрэглэх хөвөнгөөс үлдсэн материал болох хөвөнгийн орхидсоор хийдэг бөгөөд мөнгөн тэмдэгтийн цаасны үндсэн материал болдог. Харин мөнгөн тэмдэгтийн цаасанд шулуун (Offset printing) болон товгор хээний хэвлэлтэй (Intaglio printing) хослуулан мөнгөн тэмдэгтийн бохирдлоос хамгаалах бүрэлтүүдийг (TOPnote® UV layer) хийж өгдөг. Мөнгөн тэмдэгтийн бүтцийг дараах бүдүүвчээр харуулж байна. Үүнд:



Мөнгөн тэмдэгтийн цаасны зузааны зүсэлтийг харуулсан материалын бүтцийн зурагнаас харахад товгор хээний хэвлэлт болон хиртэлтээс хамгаалах бүрэлт зэрэг нь мөнгөн тэмдэгтийн насжилтанд ихээхэн нөлөөтэй байдаг. Гүйлгээнд идэвхитэй байж, хүний гараар олон дахин баригдаж, хиртэлт ихээр авдаг 50-т, 100-т, 500-т болон 1000-тын дэвсгэртүүд нь том дэвсгэртүүдийг бодвол харьцангуй богино насжилттай байна.

Төгрөгийн дундаж насжилтыг бусад орнуудтай харьцуулах нь

Английн Де Ла Ру компанийн хөгжиж буй орнуудад хийсэн судалгаагаар цаасан мөнгөн тэмдэгт дунджаар 2 жил насладаг гэж тогтоосон байх бөгөөд үүнтэй харьцуулбал манай улсын мөнгөн дэвсгэрт харьцангуй урт насжилттай байна. Төгрөгийн насжилтыг өндөр хөгжилтэй орнуудын дэвсгэртийн том ба бага нэрлэсэн үнэтэй дэвсгэртүүдтэй харьцуулсан үзүүлэлтийг хүснэгт 2-т харуулав..

Хүснэгт 2. Зарим орнуудын том болон бага нэрлэсэн үнэтэй цаасан мөнгөн тэмдэгтийн насжилтыг харуулсан хүснэгт (жилээр)

Улс	Бага нэрлэсэн үнэтэй дэвсгэрт Төгрөг: 500, 1000, Ам.доллар 5000, Фунт: 1, 5, 10, 5, 10, Австрали доллар: 5, 10	Том нэрлэсэн үнэтэй дэвсгэрт Төгрөг: 10000, Ам.доллар 20000, фунт: 20, 50, 20, 50, Австрали доллар: 20, 50
Монгол	3.2	5.0
Америк	5.3	8.2
Австрали	6.2	12.2

Австрали Улс полимер дэвсгэрт ашигласнаар дундаж насжилт нь харьцангуй урт байна.

Монгол Улс 20000-тын дэвсгэрт 2006 оны сүүлээс гүйлгээнд гарсан бөгөөд том дэвсгэртийн насжилтыг уртасгахад нөлөө үзүүлсэн.

Төгрөгийн дундаж насжилтанд нөлөөлж буй хүчин зүйлс

Хуурай, эрс тэрс уур амьсгалтай, тоосжилт ихтэй манай улсын мөнгөн тэмдэгт бохирдож муудах нь их байдаг. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбар түлхүү хөгжсөн, том газар нутагтай, эдийн засгийн шилжилтийн байдалд байгаа манай орны иргэдийн мөнгөтэй харьцах соёл, хэвшил сул хэвээр байгаа нь дэвсгэртийг халааслах, нугалах, бохирдуулах зэргээр илэрдэг. Дараах хүчин зүйлс төгрөгийн дундаж насжилтанд нөлөөлж байна. Үүнд:

Уур амьсгал


Иргэдийн соёл

Картын хэрэглээ

Мөнгөн тэмдэгтийн материалын чанар

Сүүлийн үед банкууд гүйлгээнээс шимтгэл авах болсон нь бэлэн бусыг сонирхолгүй болгож байна.

Устгагдаж буй дэвсгэртийн 75 хувийг хиртэж бохирдсон, 15 хувийг нугаларч тасарсан, үлдсэн хувийг урагдсан дэвсгэртүүд эзэлж байна.



Бэлэн бус төлбөр тооцооны систем нь бэлэн мөнгийг орлож, улмаар дэвсгэртийн дундаж насжилтанд эерэгээр нөлөөлдөг. Манай оронд банкны картын үйлчилгээ 1999 оноос хөгжиж ирсэн бөгөөд карт эзэмшигчийн тоо 2006 онд 251.0 мянга байсан бол 2016 онд энэ үзүүлэлт огцом өсч, давхардсан тоогоор нийт 4.3 сая ширхэг картыг идэвхтэй, идэвхгүй хэлбэрээр хэрэглэж байна. Энэ нь банк санхүүгийн үйлчилгээ илүү хялбар, найдвартай, шуурхай болж бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ өсч, картаар үйлчлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд, бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүн, үйлчилгээндээ картын соёлтой хэрэглээг хэвшил болгож байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Картын тоо

	2014 он	2015 он	2016 он	Өсөлт/бууралт	
Картын тоо	3 574 646	4 058 900	3 953 989	- 104 911	-2.58
Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо	1 361 630	2 289 811	1 468 376	-821 435	-35.87

+ өссөн үзүүлэлт, - буурсан үзүүлэлт

Дүгнэлт

Цаашид том дэвсгэртүүдийн насжилтыг уртасгах талаар арга хэмжээ авах шаардлагатай байна. Дэвсгэртийн насжилтыг програмын аргаар тооцоход жигнэсэн дундаж насжилт нь 3.88 жил байна. Судалгаанаас үзэхэд 5000, 10000 болон 20000-тын том дэвсгэртүүдийн насжилт бусад дунд болон жижиг дэвсгэртүүдтэй харьцуулахад урт настай байна.

Цаашид мөнгөн тэмдэгтийн чанарыг тогтмол сайжруулах, иргэдийн бэлэн мөнгөтэй харьцах соёлыг сайжруулан, бэлэн мөнгөтэй цэвэрхэн харьцаж хэвшүүлэх, бэлэн бус төлбөрийн хэрэгслийг өргөжүүлэх ажлыг тогтмол хийх шаардлагатай байна.

МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ГАЗАР.

“Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ” аяны хүрээнд сэтгүүлчдийн дунд зарласан нийтлэлийн уралдааны шилдэг бүтээл.

ТӨГРӨГ ХҮҮГИЙН ЗОВЛОН

Алс холын Европын оронд үйлдвэрлэгдсэн Төгрөг хүү анд нөхдийн хамт агаарын тээврээр Монголд иржээ. Нүүрэн дээрээ соёмбо, түүхэн хүнийхээ хөргийг залсан Төгрөг хүү эх нутагтаа ирээд амар жимэр сайхан амьдрах гэгээхэн мөрөөдөл тээжээ.

Хуруу эсгэм шинэхэн, ганган дэгжин нүүртэй, гялгар хатуу цаастай, содон үнэртэй Төгрөг хүү эдийн засгийн эргэлтэд орж, элгэн олон монголчууддаа тус дэм болох мөчийг тэсэн ядан хүлээнэ. Ингээд хүсэн хүлээсэн өдөр нь ирж, сар шинийн өмнөхөн АТМ-аар тэтгэврээ авч буй эмээгийн гар дээр очив. Эмээ ч “Төрийн минь хишиг” хэмээн Төгрөг хүүг дээдэлж, духандаа нэг хүргээд нямбай гэгч нь түрийвчиндээ хийжээ. Арьсан түрийвчинд анх удаа орж үзсэн Төгрөг хүүд аятайхан сайхан мэдрэмж төрж байв. Сар шинийн баяр ч болдгоороо болж, азай буурал эмээ ач хүүгийнхээ гарыг цайлгана хэмээн Төгрөг хүүг гоёмсог дугтуйнд хийн барьжээ. Арван хэдхэн настай ач хүү нь харин дугтуйтай Төгрөг хүүг харан баяссанаа шүүрэн авч голоор нь нугалаад ширүүн өмднийхөө халаасанд шургуулж орхив. “Мэндэлсэн” цагаасаа эхлэн нугарч, хугарч үзээгүй Төгрөг хүүгийн хамаг бие шархиран өвдөн ёолон гаслан байвч эрхийн тэнэг ач хүүгийн чихэнд сонсогдохгүй нь гачлантай. Мөнгөний үнэ цэнийг мэдэхгүй хүү хөөрхий түүнийг хаймран тоглоомоор сольж орхижээ. ТҮЦ-ийн худалдагч гуай ч Төгрөг хүүг шуналтай гэгч нь шүүрч авснаа бяцхан хайрцаг руу шидэж орхив. Өвдөж ёолон Төгрөг хүү арайхийн нүдээ нээтэл дайн дажинд нэрвэгдсэн аятай халтартаж үрчийсэн хэдэн дэвсгэрттэй таарах нь тэр. Өнөө хэдэн дэвсгэрт нь өөр зуураа гаслан ёолж, мэнд мэдэхтэй манатай хэвтэж байлаа.

Ширүүхэн гартай, чангахан дуутай худалдагч гуай Төгрөг хүүг халтар гараараа шүүрэн авч, хар зах руу хангинаж өгөв. Эндээс тэрбээр Төгрөг хүүг хэдэн ногоогоор сольж авлаа. Хүнсний ногооны худалдагч ч Төгрөг хүүг хайрлаж энхрийлсэнгүй. Шороотой төмс, лууван барьсан халтар гараараа жишим ч үгүй базаж аваад ноорхой цүнхнийхээ ёроолд чихэв. Төгрөг хүү энэ үед тэсэхийн аргагүй их өвдөж байсан ч ёолох тэнхэл үлдсэнгүй. Ухаан нь орж гарч байсан ч уужуу сэтгэлтэй монголчууд түүний биеийг хайрлаж гамнана гэсэн битүүхэн горьдлогоо тээсээр л байлаа.

Ногооны худалдагч гуай харин ноорхой хэдэн дэвсгэрттэй хамт Төгрөг хүүг хэдэн килограмм махаар сольж орхив. Махны худалдагч гэх мантигар шар хүүхэн малилзтал инээж байгаад мөнгөн дэвсгэртийг шүлсдэн тоолжээ. Шүлс, шүүс болсон хөөрхий Төгрөг хүү хаана очиж биеэ барах юм бол доо гэж сэтгэлдээ битүүхэн шаналж эхлэв. Уг нь, тэр нас залуу, бие чийрэг, зүс царай тунгалагсан. Хэдхэн хоногийн дотор анд нөхөд нь танихааргүй хачин аймар, үзээрийн болсондоо үнэхээр ичиж байлаа. Үрчийж, хорчийтлоо базуулж, хир даг, шүлс, шүүсэнд даруулсан хөөрхий Төгрөг хүүгийн зовлон үүгээр дууссангүй ээ. Махны худалдагчаас хүнсний тасаг руу, хүнсний тасгаас хувцасны лангуу руу шилжиж, бараагаа зарсан наймаачны цохилтод өртөж, тоолох болгонд шүлс нэмэгдэж явсаар тарган эрийн зузаан түрийвчинд орлоо. Түүний хэтэвч хэдий арьсаар урласан, эдэлгээ чанар сайтай ч хирэндээ баригдаж, Төгрөг хүүгээс өөрцгүй болсон халтар дэвсгэртээр дүүрчээ. Эндээс хуруу зүсэм, содон соньхон үнэртэй анд найзуудаас нь нэг нь ч харагдсангүй. Бодвол Төгрөг хүүтэй адилхан хувь зохиолоор үйлээ эдэлж, танихын аргагүй болоо биз.

Тарган эр нэгэн орой түрийвчтэй мөнгөө шүлсдэн тоолж эхэллээ. Нэг, хоёр, гурав, ... есөн зуун ерэн найм, ерэн ес, мянга... Азгүй Төгрөг хүү мянгад нь таарч орхив. Тэгмэгц тарган эр уухилан байж улаан бал гаргаж ирснээ хөөрхий Төгрөг хүүгийн халтардаж, үрчийсэн бие дээр сараачиж тэмдэглэлээ. Биеийг нь урж, тасдаж байгаа мэт өвдөж, байдаг тэнхээгээрээ хашхирсан боловч эзнийхээ чихэнд дуулдсангүй. Ингээд эрээн мяраан болтлоо сийчүүлсэн Төгрөг хүү ухаан алдаж, хэчнээн хүний хэдэн халтар гар, түрийвч, халаас дамжсанаа ч мэдсэнгүй.

Нэг сэртэл архины ааг, тамхины бохь үнэртүүлсэн хүний гутлын түрийнээс гарч иржээ. Согтуу эр Төгрөг хүүг эхнэрээсээ нууж, гуталдаа хийсэн ч эргээд ашиглахдаа урж тасадсан байна. Хөөрхий Төгрөг хүү цэл залуугаараа олон зовлон үдэж, эцэстээ нугарч, хугалсан хэсгээрээ ийнхүү тасран дахин ашиглагдахын аргагүй болжээ.

Эх сурвалж: Өглөөний сонин

МӨНГӨН ТЭМДЭГТ ХУУРАМЧААР ҮЙЛДЭХТЭЙ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЗААЛТУУД:

Төв банкны тухай хууль:

9-р зүйл: Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэхтэй тэмцэх

Мөнгөн тэмдэгтийн хуурамч эсэхийг Монголбанк тогтооно.

Хуурамч мөнгөн тэмдэгтийг Монголбанк устгана.

Мөнгөн тэмдэгтийг хуурамч эсэхийг тогтоох, хуурамч буюу хуурамч байж болзошгүй мөнгөн тэмдэгтийн талаархи мэдээлийг хүлээн авах, хуурамч мөнгөн тэмдэгтийг устгахтай холбогдсон журмыг Монголбанк тогтооно.

Эрүүгийн хууль:

158 дугаар зүйл: Үнэт цаасны тухай хууль тогтоомж

158.1. Үнэт цаас гаргах, гүйлгээнд оруулах, худалдах, арилжих, түүгээр төлбөр тооцоо хийх, брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах журмыг зөрчсөний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

158.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

176 дугаар зүйл: Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах

176.1. Монгол Улсад төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөрийн бусад хэрэгсэл, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж ашигласан, борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар

хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

176.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, урьд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

176.3. Энэ хэргийг зохион байгуулалтай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас бусдад онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж арваас дээш арван таван жил хүртэл хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/:

18.7 дугаар зүйл: Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах

1. Үнэт цаас, цахим карт, төлбөрийн бусад хэрэгсэл, онцгой албан татварын тэмдэгт, санхүүгийн баримтыг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж хадгалсан, ашигласан, зөөвөрлөсөн, тараасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Монгол Улсад төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа үндэсний, гадаад улсын мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж ашигласан, хадгалсан, зөөвөрлөсөн, тараасан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.



МОНГОЛБАНК

ТӨРӨӨ ДЭЭДЭЛЖ ТӨГРӨГӨӨ ХҮНДЭЛЬЕ!

ЧИНГИСИЙН ХӨРӨГТЭЙ ТӨГРӨГ

Төрийн сүлдтэй шүү дээ
Төгрөг цолтой шүү дээ
Төр засаг эзэнтэй шүү дээ
Түмэн ардын ерөөлтэй шүү дээ

Намайг хүндлээрэй
Намайг үнэлээрэй
Саяар нь өсгөөрэй
Сайхан хадгалаарай

Эзэн Чингисийн хөрөнгөтэй шүү
Эгэл түмний өвөрт шүү дээ
Алтан баталгаа нь чанга шүү дээ
Азийн Монголын валют шүү дээ

Намайг хүндлээрэй
Намайг үнэлээрэй
Саяар нь өсгөөрэй
Сайхан хадгалаарай

Жанжин Сүхийн дүртэй шүү дээ
Заяа жаргалын урилга шүү дээ
Буян буяны шүншигтэй шүү дээ
Даян дэлхийд данстай шүү дээ

Намайг хүндлээрэй
Намайг үнэлээрэй
Саяар нь өсгөөрэй
Сайхан хадгалаарай

Увс аймаг дахь Монголбанкны Салбарын нярав Н.Пэлжид

МӨНГӨН ТЭМДЭГТИЙН НУУЦЛАЛ, ТАНИХ ТЭМДЭГ

2006 оны 20000-тын дэвсгэрт



Дэвсгэр зургийн зүүн доод талын босоо, хэвтээ ирмэгийн дагуу "MONGOLBANK" гэсэн үгийг маш жижгээр бичсэн.

Холограмм дардас дотор, Соёмбо үсэг, 20000-тын тоо **солонгорч харагдана.**



Дэвсгэртийн хоёр талд байрлах Чингис Хааны гэрэгэгийн дээд хэсгийн дугуй дүрсүүд зөрүүгүй **давхцана.**



Дэвсгэртийн дэвсгэр зураг, ялангуяа "Монгол Улс" гэсэн эвхмэл бичиг, "20000" төгрөгийн нэрлэсэн үнийн тоо гарт мэдрэгдэхээр **товгор.**



Тусгай гэрлээр харахад Соёмбо үсгийн хүрээ Чингис Хааны хөрөг, 20000 гэсэн тоо **гэрэлтэнэ.**



Гурван мм-ийн өргөнтэй тасалдаж харагдах металл утсан дээр "MONGOLBANK" гэсэн үг, Соёмбо үсэг солигдож **харагдана.**



Дэвсгэртийн нүүрэн талын баруун хэсгийг гэрлийн эсрэг барьж харахад Чингис Хааны хөрөг, "МБ" гэсэн үсэг бүхий усан хээ тодорно.

Налуугаас харахад дөрвөн морьтон баатрын дүрс, дэвсгэр өнгө нь дөрвөн хэсэгт **тодорно.**

Хэрэв танд эргэлзээ төрвөл сэжигтэй дэвсгэртийг жинхэнэтэй нь харьцуулж үзээрэй.



Мөнгөн тэмдэгтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар авна уу: www.mongolbank.mn.
МОНГОЛ БАНК

